

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-11
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	12-

1.“Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ	16-31
2.Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай асуудал	31-35 43-52
3.Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 83 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэх	35-42
4.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/	42-43
5.Хот байгуулалт, төлөвлөлт, барилга, орон сууц, инженерийн дэд бүтэц, нийтийн аж ахуйн өнөөгийн нөхцөл байдал, иргэдийг хямд үнээр орон сууцжуулах хөтөлбөрийн явц, ипотекийн зээл олголтын талаар, Улаанбаатар хотын агаарын бохирдол, автозамын түгжрэлийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр салбарын яамны авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын мэдээллийг сонсох	хойшлуулав
6.Аялал жуулчлалын дэд бүтцийн хөгжил, аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлэх боломж, дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын мэдээллийг сонсох	хойшлуулав
7.Малын гаралтай түүхий эдийн экспортыг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилт, зохицуулалтын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох	хойшлуулав

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 12 дугаар сарын 24-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 16 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: О.Батнайрамдал, Ш.Бямбасүрэн;
Чөлөөтэй: Ч.Лодойсамбуу;
Тасалсан: Х.Баттулга, Д.Энхтүвшин.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаас Малын гаралтай түүхий эдийн экспортыг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилт, зохицуулалтын талаарх мэдээлэл сонсох тухай асуудлыг хойшлуулах тухай хүсэлт ирүүлснийг танилцуулж, уг асуудлыг хэлэлцэхийг хойшлуулав.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, Ж.Ганбаатар, Х.Ганхуяг нар үг хэлж, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Р.Сэддорж хариулж, тайлбар хийв.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн гаргасан, Хот байгуулалт, төлөвлөлт, барилга, орон сууц, инженерийн дэд бүтэц, нийтийн аж ахуйн өнөөгийн нөхцөл байдал, иргэдийг хямд үнээр орон сууцжуулах хөтөлбөрийн явц, ипотекийн зээл олголтын талаар, Улаанбаатар хотын агаарын бохирдол, автозамын түгжрэлийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр салбарын яамны авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын мэдээлэл болон Аялал жуулчлалын дэд бүтцийн хөгжил, аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлэх боломж, дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын мэдээллийг хэлэлцэхийг хойшлуулах тухай горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16

56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул дээрх асуудлуудыг хойшлуулахаар тогтов./10:34/

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 16 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Нэг.“Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл

боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, мөн яамны Гэрээ, эрх зүйн газрын дарга Г.Эрхэмбаяр, “Дулааны цахилгаан станц-3” Төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар, мөн компанийн Техникийн бодлогын хэлтсийн дарга Г.Амартүвшин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Бат.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, Дотоод хяналтын хэлтсийн зөвлөх Б.Хонгорзул нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь үг хэлж, Байнгын хорооны дарга Р.Сэддорж тайлбар хийв.

Төслийн талаар Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг, О.Цогтгэрэл, Ж.Алдаржавхлан, Г.Лувсанжамц, Х.Ганхуяг нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, П.Сайнзориг, С.Цэнгүүн нар үг хэлэв.

Р.Сэддорж: “Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	11
Бүгд:	20

45.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	13
-------------	----

Татгалзсан: 7
Бүгд: 20
65.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 6
Бүгд: 20
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Бат.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, Дотоод хяналтын хэлтсийн дарга Б.Төгсцэнгэл, зөвлөх Б.Хонгорзул нар байлцав.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж нэр дэвшигчдийн талаар танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.6 дахь заалтын дагуу нэр дэвшигч нэг бүрээр санал хураалт явуулав.

Р.Сэддорж: Нинжбатын Ууганбаатарыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, Г.Лувсанжамц, Х.Ганхуяг, Б.Найдалаа, Б.Мөнхсоёл, Ж.Алдаржавхлан нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Р.Сэддорж, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж нэр дэвшигчдийн талаарх санал хураалтыг түр хойшлуулав./11:44/

Гурав.Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 83 дугаар захиралжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэх

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Бат.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, Дотоод хяналтын хэлтсийн дарга Б.Төгсцэнгэл, зөвлөх Б.Хонгорзул нар байлцав.

Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Г.Лувсанжамц нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авах талаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Р.Сэддорж: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	7
Бүгд:	20

65.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 20 гишүүнээс 14 гишүүн дэмжиж, 70.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Бат.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, Дотоод хяналтын хэлтсийн дарга Б.Төгсцэнгэл, зөвлөх Б.Хонгорзул нар байлцав.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж тогтоолын төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Р.Сэддорж хариулж, тайлбар хийв.

Р.Сэддорж: “Нэр дэвшигчийн сонголын тов тогтоох, сонгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 5
Бүгд: 20
75.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Нэр дэвшүүлэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Алдаржавхлан нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Р.Сэддорж, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ү.Амарбат нар хариулж, тайлбар хийв.

Р.Сэддорж: 1.Нинжбатын Ууганбаатарыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 6
Бүгд: 20
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Цолмонгийн Бархасыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 20
Бүгд: 20
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Ганхүүгийн Батхонгорыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 19
Бүгд: 20
5.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Даваагийн Ганбаярыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 18
Бүгд: 20
10.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 13
Бүгд: 20
35.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 11
Бүгд: 20
45.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Р.Сэддорж: 5.Сугарын Лхагвадоржийг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 12
Бүгд: 20
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Дэмчигжавын Моломжамцыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 16
Бүгд: 20
20.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Ралгаагийн Пүрэвийг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 11
Бүгд: 20
45.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул нэр дэвшигч Д.Моломжамц, Р.Пүрэв нарын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 10
Бүгд: 20
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: Горимын санал дэмжигдсэн тул Ралгаагийн Пүрэвийг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлж, Байнгын хорооны дарга Р.Сэддорж тайлбар хийв.

Р.Сэддорж: 8.Тунсагийн Тэлмэнг Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 13
Бүгд: 20
35.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны хуралдаан 12 цаг 47 минутаас 15 цаг 45 минутад завсарлав.

Хуралдаанаар Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн,

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Р.Сэддорж: 1.Сугарын Лхагвадоржийг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Тунсагийн Тэлмэнг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Гэрэлтийн Тэлмэнг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Гомбын Эрдэнэбаярыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Данзанбалжирын Энхжаргалыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ундраагийн Хосжаргалыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6

Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 17 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх асуудлаар санал хураалт явуулав.

Р.Сэддорж: 1. Намсрайн Батнасанг Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 17 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Раднаасэдийн Даваадоржийг Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3. Батбаатарын Мөнхзаяаг Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4. Бямбажавын Энх-Амгаланг Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа санал хураалтын дүнг дэмжсэнээр

хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 17 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх асуудлаар санал хураалт явуулав.

Р.Сэддорж: Булганы Саруулыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвшүүлэх асуудлаар санал хураалт явуулав.

Р.Сэддорж: 1.Мягмарсүрэнгийн Буяндэлгэрийг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Оюунтөгсийн Очийг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Болдбаатарын Энхбаярыг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх асуудлаар санал хураалт явуулав.

Р.Сэддорж: 1.Төмөрбаатарын Гарамжүгдэрийг Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Дамдиндоржийн Мягмарцэрэнг Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж Улсын Их Хурлаас Авирмэдийн Даваасүрэнг Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнд шууд сонголд оруулах тухай хэлэв.

Уг асуудлыг 16 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 53 минут үргэлжилж, 25 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 07 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим 10 цаг 16 минут.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн өглөөний амгаланг айлтгая.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Хуралдаанд Сэддорж, Алдаржавхлан, Бадамсүрэн, Батболд, Батчимэг, Ганбаатар, Ганхуяг, Мандхай, Мөнхсоёл, Соронзонболд, Ундраа, Цогтгэрэл, Мөнхцэцэг, Энхцэцэг гишүүд оролцож байна. Батсүмбэрэл гишүүн чөлөө авсан байна. Хуралдааны ирц 52 хувьтай байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52 хувьтай байгаа учраас Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 12 сарын 24-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1. Монгол Улсын Улаанбаатар хотын дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл. Засгийн газар 2024 оны 12 сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ.

2. Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн, СЗХ-ны орон тооны бус гишүүн, СЗХ-ны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, ҮСХ-ны зөвлөлийн гишүүнд тус тус нэр дэвшүүлэх тухай асуудал.

3. Байнгын хорооны тогтоолын төсөл. Энд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай.

4. Хот байгуулалт, төлөвлөлт, барилга орон сууц, инженерийн дэд бүтэц, нийтийн аж ахуйн өнөөгийн нөхцөл байдал, иргэдийг хямд үнээр орон сууцжуулах хөтөлбөрийн явц, ипотекийн зээл олголтын талаар, Улаанбаатар хотын агаарын бохирдол, авто замын түгжрэлийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр салбарын яамны авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын мэдээллийг сонсох.

5. Аялал жуулчлалын дэд бүтцийн хөгжил, аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлэх боломж, дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын мэдээллийг сонсох.

6. Малын гаралтай түүхий эдийн экспортыг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилт, зохицуулалтын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох.

7. Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 83 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэх гэсэн 7 асуудал өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхээр хоногийн тов дараалалд батлагдсан байгаа.

Эдгээр асуудлуудаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд энэ 7 хоногт томилолтоор ажиллаж, Дархан хотдоо хөдөө аж ахуйн чиглэлээр ажиллаж байгаа учраас мэдээллийг хойшлуулж өгнө үү гэсэн хүсэлт ирүүлсэн. Тиймээс сайдын мэдээллийг хойшлуулж байна.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Батчимэг гишүүн, Ганбаатар гишүүн нар.

Батчимэг гишүүний микрофоныг нээе.

П.Батчимэг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн өглөөний амар амгаланг айлтгая.

Миний бие нэг горимын санал гаргая. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4.1.3-д заасны дагуу Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулаад энэ Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Соёл спорт, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд гэсэн 3 сайдын мэдээллийг сонсох ийм асуудлууд орж ирж байна. Энд нэг 3 асуудал ярья гэж бодож байгаа юм. Яагаад гэхээр энэ хэлэлцэх гэж байгаа асуудлууд өнөөдөр гишүүдийн гар дээр ерөөсөө ирээгүй байна л даа. Өчигдөр 22 цагт гэхэд Хот байгуулалтын яамны юу материал орж ирсэн. Өнөө өглөө Аялал жуулчлалын сайдын материал орж ирсэн. Тэгээд энэ гишүүдийн унших, танилцах, судлах энэ боломжийг олгохгүй байна гэж 1 дүгээрт, үзэж байна.

Ингээд энэ байдал сүүлийн үед ер нь олон удаа давтагдаж байна. Хэд хэдэн удаа давтагдаж байна. Энэ асуудалд Улсын Их Хурлын Тамгын газар, Байнгын хороо анхаармаар байна.

2-т, Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.1 дэх хэсэгт хуульд заасны дагуу эсвэл Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд өөрийн санаачилгаар гэж байгаа юм. Би энэ дэгийн тухай хуулийг нь харсан юм. Өөрийн санаачилгаар Засгийн газрын гишүүд Улсын Их Хуралд ажлаа шууд тайлагнадаг. Байгууллагын болон бусад байгууллагын мэдээллийг хуралдаанаараа хэлэлцэж болно гэж заасан байгаа. Өнөөдрийн манай Эдийн засгийн байнгын хорооны энэ хуралдаанаар энэ Засгийн газар, сайд нарын асуудлыг өөрийн санаачилгаар мэдээллийг нь сонсох гэж байгаа юу, эсвэл хуульд заасны дагуу хэлэлцэх гэж байгаа юм уу гэдгийг энэ асуултад нэг хариулт авъя гэж.

3 дугаарт нь, энэ сайд нарын мэдээллийг сонссоноороо өнөөдрийн энэ Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаас яг ямар шийдвэр гарах юм. Байнгын хорооноос сайд нарт үүрэг, чиглэл, албан шаардлага гэх мэтийн зүйлүүдийг

тэмдэглэл, ийм юмнууд гарах юм уу? Байнгын хороо ийм чиглэл, үүрэг даалгавар, тэмдэглэл ийм юм гаргах уу? Хэрвээ энэ манай Байнгын хорооноос ямар нэгэн тодорхой шийдвэр ч юм уу, ямар нэгэн тодорхой үр дүн гарахгүй асуудлаар мэдээлэл, гишүүд сонсох хэрэг байна уу? Гишүүд маш их ачаалалтай ажиллаж байгаа шүү дээ. Одоо сая гэхэд л ийм том анагаахын анатомийн ном шиг ийм зузаан материал энэ өглөө ингээд хэвлээд ороод ирж байгаа юм. Бидэнд чинь бас нэг унших, судлах, танилцах, энэ зөвлөхүүдтэйгээ ярилцах, ажлын албатайгаа ажиллах зөндөө цаг хугацаа бид нарт хэрэгтэй.

Энэ Барилга, хот байгуулалтын сайдын мэдээлэл дээр маш олон том цогц асуудлууд орж ирсэн байгаа юм. Энэ олон асуудлыг бид нар салгаж, бүр 1, 1-ээр нь ч юм уу, юу асуудлыг авч Байнгын хороогоороо хэлэлцэх ийм бид нарт шаардлага байгаа. Тэнд бүр ингээд инновац, тэгээд орон сууцжуулалт, ипотек тийм ээ. Энэ олон асуудлуудыг нэг ингээд цогцоор нь оруулаад ирэхээр гишүүд үнэхээр мэргэжлийн зарим нэг гишүүд бол мэргэжлийн салбарын орж ирсэн гишүүд өөрийнхөө асуултыг асуугаад ингээд явчихна.

Р.Сэддорж: Батчимэг гишүүнд микрофон өгье. Гүйцээж 1 минут.

П.Батчимэг: Үнэхээр оруулж ирж байгаа Засгийн газрын гишүүд, сайд нарын оруулж ирж байгаа энэ Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх ажлын хүрээнд оруулж ирж байгаа асуудлууд нь маш тийм том томоор оруулж ирээд байна. Яамнууд Байнгын хорооноос асуухаар Байнгын хорооны ажлын албанаас удаа дараа материалаа асуугаад, ирж байна уу, цонхон дээр байна уу, цахимаар явуулах уу, ингээд асуугаад байхад ирээгүй байна, яамнаас ерөөсөө материалаа өгөхгүй байна гэдэг. Ингэж тулгаж урьд шөнө нь 22 цагт авсан энэ зузаан материалуудыг гишүүд уншиж, танилцаж амжих уу? Энэ 3 миний гаргасан санал дээр горимын санал дээр гишүүд, манай Эдийн засгийн байнгын хорооны гишүүд хариуцлагатай гишүүд байгаа учраас санал хураалгахыг хүсэж байна. Хэлэлцэхгүй ч байх эрхтэй. Тийм учраас хэлэлцэх үү, хэлэлцэхгүй юү? Яагаад гэвэл манай Байнгын хороо өөрсдөө эрхлэх ажлынхаа хүрээнд энэ сайд нарын Засгийн газрын гишүүдийн мэдээллийг сонсож ч болно, сонсохгүй буцааж ч болох юм байна лээ.

Тийм учраас үүнийг энэ дээр миний ... /минут дуусав/

Р.Сэддорж: Ж.Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Энэ 7 дугаар асуудал. Энэ хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх холбогдох арга хэмжээ авах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай гээд. Энэ зүгээр Байнгын хороо хэлэлцээд чуулганд орохгүй зүгээр тогтоол бараг батлагдчих юм шиг байна лээ л дээ. Байнгын хорооны тогтоол тийм ээ. Үүнийг нэг эргэж харахгүй бол энэ 4 дүгээр заалт дээр нь энэ төрийн нийтийн өмч, байгалийн баялаг ачихтай холбоотой дуудлага худалдаа эсвэл сонгон шалгаруулалтын журмыг нарийвчлан зохицуулах, дуудлага худалдаа сонгон шалгаруулалтаар төсөвлөж буй орлогыг холбогдох эрх зүйн зохицуулалт гээд энэ нэлээн тийм Байнгын хорооны дарга аа. Нэлээн ийм ноцтой заалт. Энэ бол маш ноцтой, тийм. Энэ бол ер нь цаана нь энэ бараг лицензийн наймаа цэцэглэх ийм үүд хаалга нээгдэнэ шүү.

Тэгээд сүүлд нь Их Хурлаас Эдийн засгийн байнгын хорооноос чиглэл өгсөн шүү дээ гээд. Тэгээд Их Хурал руу хаяад л өнгөрөх ийм асуудал үүснэ. Тэгээд сайд

байсан хүний хувьд би үүнийг 1 дүгээрт, нэлээн сайн анхааралтай юу яах ёстой. Энэ бол шууд дуудлага худалдаагаар явчихдаг асуудал биш шүү. Монгол Улсын баялаг. Энэ нэг сонгон шалгаруулах журам, Мийгаа, одоо энэ сонгон шалгаруулах асуудал нь их олон юмыг давж байж энэ ингээд өнөөдрийн энэ тогтолцоо бүрдсэн байгаа шүү дээ. Тэгээд энэ тогтолцоог нэлээн орвонгоор нь эргүүлэх заалт байгаа байхгүй юу, энэ.

Тэгээд энэ янз янзын юм чихэнд сонсогдоод л байсан юм л даа. Тэгэх гэж байна, ингэж байна гээд л. Тэгэхээр энэ арай болоогүй байх. Түүнээс гадна зүгээр Батчимэг гишүүний санал дээр хэлэхэд энэ асуудал сая л дөнгөж юугаар ирсэн л дээ, зөвлөх өө, дөнгөж сая юугаар ирж байна лээ, онлайнгаар ирж байна лээ. Тэгээд энэ бол өөрөө тэгээд би зүгээр бусад асуудал дээр нь Зөвшөөрлийн тухай хуулийн ажлын хэсэг дээр ярих юм алга байна л даа. Зөвхөн энэ асуулт болохгүй ээ, энэ яагаад ч болохгүй шүү. Үүнийг хэлэлцээд л баталчих юм бол ер нь Их Хурал дээр том хариуцлага яригдана шүү. Зүгээр Байнгын хорооны дарга үүнийг ер нь ийм зүйл хэрэгжүүлэх нэлээн том үүд хаалга нээж өгнө өө гэдгийг бас танд анхааруулж хэлье. Энэ ер нь болохгүй байх.

Р.Сэддорж: Ганхуяг гишүүнд микрофон өгье.

Х.Ганхуяг: Зөвшөөрлийн хуулиар 22 төрлийн төрийн нийтийн өмч, байгалийн баялгийг дуудлага худалдаа сонгон шалгаруулах хийхээр, хуулиар зохицуулсан байдаг. Хуучин гарын үсгээр явдаг байсан, ан амьтан ч байдаг юм уу, нөгөө загас байдаг юм уу, нөгөө шонхор шувуу байдаг юм уу, самар байдаг юм уу, нөгөө ховор ургамал ч байдаг юм уу, энэ голцуу эндээс орж ирж байгаа сонгон шалгаруулалт, дуудлага худалдааны орлогыг яг одоогийн нөхцөл байдлаар яаж байна гэхээр зүгээр Төрийн сан дээр ингээд орчхоод байгаа юм. Уг нь бол, жишээлбэл тэр ан амьтан бол буцаагаад эргээд тэр ан амьтныхаа үржүүлэг, хамгаалах, өвөл нь тэр шаардлагатай хадлан эд нарыг нь өгөх ч байдаг юм уу ийм байдлаар олон улсын практикт байдаг юм.

Тийм учраас үүнийхээ зохицуулалтаа сайжруулаач ээ л гэдэг ийм чиглэл өгч байна, Засгийн газарт. Түүнээс биш лицензтэй холбоотой юм, тийм юм, ерөөсөө байхгүй. Тэгэхээр нөгөө, энэ чинь нөгөө дуудлага худалдаагаар явж байгаа юм. Тийм, яах вэ энэ бүгдээрээ хуулиараа зохицуулагдаж байгаа л даа. Хамгийн гол энэ сонгон шалгаруулалт нь бүгдээрээ хуулиар зохицуулагдаж байгаа. Гол нь эндээс орж ирж байгаа орлогыг нь л тэр холбогдох эрх зүйн нөгөө оновчтой болгооч ээ л гэдэг асуудал байгаа юм.

Р.Сэддорж: Тогтоолын агуулгыг хэлэлцэх үеэр нь 7 дугаар асуудал дээр ярилцъя.

Ингээд горимын санал гаргасан Батчимэг гишүүний горимын санал байгаа тийм ээ, сайд нарын мэдээллийг хойшлуулъя гэсэн Батчимэг гишүүний горимын санал байгаа. Энэ бол яамнуудын асуултад хариулахад, энэ яамнуудын мэдээлэл бол эрхлэх асуудлын хүрээнд харьяалагддаг яамнуудынхаа мэдээллийг өөрсдийн санаачилгаар Байнгын хорооноос санаачлаад ингээд сонсож байгаа юм. Тэгээд яаралтай энэ 1-ээс, 2-оос дээш нэг хурал дээр 2 яамны мэдээллийг сонсож, Байнгын хорооны гишүүдийг мэдээллээр хангах ийм үүргийнхээ дагуу энэ ажлуудыг зохион байгуулж байгаа юм. Энэ материалууд цаг тулж ирж байгаа нь үнэн. Яамнууд 14 хоногийн өмнө материал өг гэхэд яг өчигдөр өгч байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ яамнуудын өөрсдийн хариуцлагын асуудал байна. Энэ манай ажлын алба бас үүнийг шахаж шаардаж аваагүй бас хариуцлагын асуудал байгаа. Тэгээд дандаа онлайнгаар явуулчаад байгаа шүү дээ. Та бүхэн тэр тухай бүрд нь үзэж байна уу, үзэхгүй байна уу? Тэгээд тэрийгээ хэвлээд туслахдаа өгөөд хэвлэх нь та бүгдийн бас асуудал байгаа.

Өөрийн санаачилгаар, эрхлэх асуудлын хүрээнд. Ер нь Энхтүвшин гишүүн, Цэнгүүн гишүүн эд нараас бичиг ирсэн байгаа. Энэ яамдын мэдээллүүдтэй сонсьё, очиж танилцъя. Өчигдөр Эдийн засгийн хөгжлийн яамтай очъё, танилцъя гэсэн, 2 намын бүлгийн хурлууд давхцаад байсан учраас ингээд очиж чадсангүй. Ийм учраас Эдийн засгийн хөгжлийн яамтай нэн түрүүнд хэдүүлээ очиж танилцах ажилтай байгаа.

Ингээд Батчимэг гишүүн таны саналаар санал хураая, тэгэх үү?

Ингээд өнөөдөр чинь Барилгын яам байгаа. Юуны Аялал жуулчлалын яам байгаа. Тэгээд энэ 2 яамны мэдээллийг хойшлуулъя гэсэн ийм саналаар санал хураалт. Дэмжиж байгаа гишүүд хойшлуулъя гэснийг дэмжиж байгаа гишүүд санал хураалт.

56,3 хувиар санал дэмжигдэж, өнөөдрийн сайд нарын мэдээллийг дараагийн хурал хүртэл хойшлуулъя.

Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Ер нь Батчимэг гишүүний гаргасан горимын саналыг дэмжиж байна. Энэ чинь бас уншиж, судлах шаардлагатай зүйлүүд зөндөө байгаа шүү дээ. Тэгээд ингээд шийдэгдчихлээ, хойшлогдсон. Харин нөгөө өмнөх хуралдаан дээр 2 асуудал хойшилсон шүү дээ. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны мэдээлэл, нэг нь Зам, тээврийн яамны мэдээлэл. Тэгээд энэ 2 ядаж энэ хуралдаан дээр орж болоогүй юм уу. Тэр чинь материал нь тараагдаад ингээд бас 7 хоночихлоо шүү дээ. Тэр яагаад хойшлогдсон юм бол оо. Яах вэ, ер нь Байнгын хорооны хурлыг бас үр дүнтэй явуулмаар байна л даа. Товлосон цаг хугацаандаа 7 хоногийн ингээд нэг өдөр хуралдаж байгаа. Тэгээд энэ үед нь хойшлогдсон юм нь орохгүй мөртөө цаг нь тулгасан юмнууд нь ингээд гэнэт орж ирэх юм. Энэ дээр нэг хариулт авъя.

Р.Сэддорж: Дараагийн хурал 31-нд таарч байна тийм ээ. Бадамсүрэн гишүүний хэлж байгаа зөв өө. Бас өмнөх хурал дээр хойшилсон юмнууд нь шахагдаж орж ирэхгүй байгаа. Дараагийн өөр яам орж ирж байгаа учраас гишүүд бас танилцаж, үнэхээр бас амжихгүй байгаа учраас.

Саяын санал хураалт дээр Батчимэг гишүүн дэмжсэн санал өгснөөр аваарай. Энэ төхөөрөмж нь ажиллахгүй байгаа юм байна.

Ингээд 2 яамны танилцуулга хойшлогдоод, ингээд 5 асуудлаар хэлэлцэх асуудлыг баталъя.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Сайдууд уучлаарай.

Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны 3 дугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг, төсөл боловсруулах тухай Монгол

Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн танилцуулна. Сайдын микрофоныг нээе.

Б.Чойжилсүрэн: Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Дулааны 3 дугаар цахилгаан станц ТӨХК-ийн 48 мвт-ын хүчин чадалтай дунд даралтын хэсэг 1968-1975 онд, 100 мвт-ын хүчин чадалтай өндөр даралтын хэсэг 1976-1981 онд ашиглалтад орж, 2014 онд 50 мвт-ын хүчин чадалтай труба генератораар өргөтгөснөөр суурилагдсан хүчин чадал нь 198 мвт хүрсэн бөгөөд 56 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Тус станц нь Улаанбаатар хотын дулааны шугам сүлжээний гидравлик горимын хувьд хамгийн оновчтой байршилд байрладаг ба Улаанбаатар хотын дулаан хангамжийн хэрэглээний 32 хувийг, төвийн бүсийн цахилгаан эрчим хүчний 16 хувийг тус тус ханган ажилладаг.

Сүүлийн жилүүдэд эрчим хүч хэрэглээ жилд дунджаар 8-10 хувиар өсөж байгаа бөгөөд өвлийн улиралд ДЦС-ууд бэлтгэл тоноглолгүй ажиллаж байгаа нь насжилт өндөртэй тус станцын хувьд техникийн гэмтэл саатлаас шалтгаалан хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хязгаарлах эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байна. Энэхүү эрсдэлийг бууруулахын тулд тус станцыг ойрын хугацаанд өргөтгөн шинэчлэх шаардлагатай юм.

Улаанбаатар хотын одоогийн болон өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээг найдвартай хангах зорилгоор Дулааны 3 дугаар цахилгаан станцыг 2 үе шаттай өргөтгөн шинэчлэхээр төлөвлөсөн бөгөөд эхний үе шатанд 50мвт-ын дулааны станцыг шинээр барьж, дараагийн шатанд ашиглалтын хугацаа дууссан 48 мвт-ын станцын суурин дээр 250 мвт-ын ДЦС-ыг шинээр барина. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол Оросын Засгийн газар хоорондын комиссын 2021 оны хуралдааны үеэр Оросын талаас Интер РАО Экспорт компанийг Дулааны 3 дугаар цахилгаан станцыг 2 үе шаттай өргөтгөн шинэчлэх төсөлд оролцохыг дахин илэрхийлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн 2021 оны 12 дугаар сард ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр ДЦС 3 ТӨК болон Интер РАО Экспорт хооронд хамтран ажиллах санамж бичгийг байгуулж, төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг эхлүүлжээ.

Интер РАО Экспорт компаниас төслийн ТЭЗҮ-ийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж, 2022 оны 8 дугаар сард ДЦС 3 ТӨК-д хүлээлгэн өгсөн. Төслийн нийт төсөвт өртөг болон барилга угсралтын ажлын хугацааг бодитоор тодорхойлохын тулд эхний ээлжид ЭХЯ-наас Дулааны 3 дугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн зураг төсөл боловсруулах, төсөв боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг боловсруулж Оросын талтай харилцан зөвшилцөөд байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 29 дүгээр тэмдэглэлийн дагуу Дулааны 3 дугаар цахилгаан станцын өргөтгөл шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороотой тус тус зөвшилцсөн бөгөөд Монгол Улсын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 8

дугаар сарын 30-ны өдрийн 06 дугаар тэмдэглэл, Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 48 дугаар гарын үсэг зурах эрх олгох тухай захирамжаар Эрчим хүчний сайдад хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг олгосон.

ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Владимирович Путины Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр тус хэлэлцээрт 2 улсын Засгийн газрыг төлөөлөн Эрчим хүчний сайд нар 2024 оны 9 дүгээр сарын 03-ны өдөр гарын үсэг зурсан. Олон улсын гэрээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасны дагуу Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны 3 дугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6-д заасны дагуу Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрчим хүчний сайд нар хамтран баталсан бөгөөд хуулийн төсөл түүний дагалдах тооцоо, судалгааг хийж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Хууль тогтоомжийн хуулийн дагуу Монгол Улсын Их Хуралд 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр өргөн барьсан.

Энэ хэлэлцээр нь Монголын талын хэлэлцээр соёолон батлах тухай хууль батлагдсанаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ.

Улсын Их Хурлын Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Олон улсын гэрээний тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны 3 дугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжин, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя.

Чойжилсүрэн сайд Эрчим хүчний сайд, Ерэн-Өлзий ЭХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Эрхэмбаяр ЭХЯ-ны Гэрээ, эрх зүйн газрын дарга, Эрхбаатар ДЦС 3 ТӨХК-ийн гүйцэтгэх захирал, Амартүвшин ДЦС 3 ТӨХК-ийн Техникийн бодлогын хэлтсийн дарга.

Батсуурь сайд. Батсуурь сайдын микрофоныг нээе. Протоколд.

Ж.Батсуурь: Байнгын хорооны гишүүдийнхээ өглөөний мэндийг хүргэе. Тэгээд манай яамны мэдээлэл цахимаар очсон байгаа, 1 дүгээрт.

Тэгээд 2-т, гэвэл ер нь бас Байнгын хорооны мэдээллүүд цаг цагтаа л ирээд Их Хурлын Байнгын хорооноос Их Хурал руу орж байгаа шийдвэр ч гэсэн бас ингээд цаг тулаад ордог тохиолдлууд байдаг. Тэгээд он гараад маш олон шийдвэрүүд Их Хурлаар орох гээд, хуулиуд өргөн баригдах гээд, тэгээд ондоо багтаад мэдээллээ өгье өө гээд. Тэгээд энэ түгжрэл, энэ хэцүү нөхцөл байдалд бараг яам, харьяа газруудын 10 гаруй төрийн албан хаагчдыг ажил төрлийг нь зохицуулаад ирчихсэн байхад ингээд хойшлуулж байгаад харамсалтай байна.

Тэгээд энэ Чойжоо сайд шиг мөн мэдээллээ хийгээд л, үүнийгээ эргэн тойрон ярьж, Байнгын хороо дээрээ бүх зүйлээ мэдэх боломжууд нь бид нарт байж байгаа байхгүй юу. Тэгж байж харин шаардлагатай гэх юм бол өнөөдрийн Байнгын хорооноос ахиж тийм зүйлийг тодруулж авъя, ийм зүйлийг тодруулж авъя гэсэн байдлаар асуудалд хандахгүй бол ингээд төрийн албаа улам чирэгдүүлээд ийм нөхцөл байдал үүсээд байна.

Тийм учраас өнөөдөр манай яамны мэдээллийг оруулаад, онд нь багтаад тэгээд оны өмнө гарах шийдвэрүүдэд хүлээгдэж байгаа маш олон асуудлууд байж байгаа шүү дээ. Намрын чуулган дуусах гэж байна. Түүнээс өмнө өргөн барих гэж байгаа 4 хууль байж байна. Үүнээс өмнө мэдээллээ өгье гэж бид нар намраас авхуулаад зөндөө хэлсэн шүү дээ. Тэгээд энэ цаг үед л хуваарь нь таарсан. Тэгээд хуваарьд нь тааруулаад цахимаар мэдээллээ өгсөн. Бид нар бараг 10 сард ч мэдээлэл өгөх боломжтой, 11 сард ч мэдээлэл өгөх боломжтой байсан. Тэгээд он дуусах гэж байдаг. 31-нд ирц бүрдэхгүй.

Тэгээд Байнгын хорооны гишүүдээ бүрэн бүрэлдэхүүнээр нь энэ салбарын, энэ яамны мэдээллийг маш ойлгомжтой өгөөд, та бүхнийхээ заавар зөвлөмжийг аваад өргөн барих гэж байгаа 3-4 хууль байна. Эндээ хэлж байгаа саналуудыг нь бас тусгаад ингээд явахгүй бол энэ Засгийн газрын үйл ажиллагаа, Их Хурлын үйл ажиллагаа чинь хойш нь хаясаар байтал 4 жил чинь дууслаа шүү дээ. Хойш нь хаялаа. Бид хэзээд өгөхөд бэлэн байсан шүү дээ.

Тэгээд тавьсан хуваарьт нь асуудлаа оруулаад ирэнгүүт, ингээд хойш нь тавиад, маш олон хүмүүсийг хүндрэл чирэгдэл учруулаад байна шүү дээ. Өнөөдөр гэхэд бид нар Байнгын хороонд асуудлаа тавина гээд манай яамны бүх газрын дарга нар, бүх харьяа газрын дарга нар ажлаа хийгээд хэлэлцсэн байгаа. Өнөөдөр буцахад түгжрээд өнөөдрийн бүтэн өдрийн ажил үндсэндээ дуусах гэж байгааг бид нар ойлгох хэрэгтэй.

Тийм учраас би Байнгын хорооны гишүүдийг ийм ирц өндөртэй байгаа өдрөө манай яамны мэдээллийг сонсоод, бид нарт өгөх заавар, зөвлөмжөө өгөөд, тодруулах зүйлээ тодруулаад, ингээд ирэх он гараад хаврын, намрын чуулганаас өмнө өргөн барих хуулиудын төслийг яаравчлуулахад дэм болгож өгөөч ээ гэж ингэж хүсэж байна. Ингэж бие биеийнхээ ажлыг арагш нь чирмээргүй байна. Бид нарт тэр хугацаа алдагдуулсан зүйл байхгүй шүү дээ. Цахимаар очсон. Бид нарт ирсэн, хүссэн бичгүүдийг цаг тухайд нь өгч байгаа шүү дээ. Бид нарт ирээгүй, тийм бичиг авъя, ийм бичиг авъя гэж ийм зүйлүүд байж байна.

Р.Сэддорж: Протоколд тэмдэглүүлж байна. Ажлын алба энэ талаар хариу бэлдээрэй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2 дахь хэсгийг баримтлан хуулийн төслийг хэлэлцье.

Чойжилсүрэн сайдын оруулж ирсэн хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Сайнзориг гишүүнээр тасалж байна. Ингээд Энхцэцэг гишүүний микрофоныг нээе. Энхцэцэг гишүүн байна уу? Энхцэцэг гишүүн асуулт асууя.

М.Энхцэцэг: Энэ дулааны танилцуулга хийсэн ЭХЯ-ныхандаа баярлалаа. ДЦС-ын 3-ыг өргөтгөх зураг төслийн ажлыг хийлгэх ОХУ-ын холбогдох байгууллагаар хийлгэх, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийн танилцуулга орж ирж байна.

Тэгэхээр энэ дээр нэг хэд хэдэн асуулт байна. 1 дүгээр асуулт болохоор энэ ерөнхийдөө энэ гэрээнээс харахаар яг зураг төслийг хийх гэрээ нь болохоор тусдаа хийгдэх юм шиг ингэж харагдаж байна л даа. Тэгэхээр энэ нь бас жаахан тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл энэ зураг төсөл дээр тухайн станцыг өргөтгөхтэй холбоотой хуваарилах байгууламж гэж байгаа. Мэдээж энэ станц чинь яг гадна байгууламж нь, хуваарилах байгууламж нь одоо байгаа хүчин чадалтай зориулагдаад хийгдчихсэн байгаа.

Тэгэхээр энэ станцын хүчин чадлыг өргөтгөхөөр гадна байгууламж буюу байгаа хуваарилах байгууламжийг өргөтгөх зураг төслийг хийх шаардлагатай болно.

Дээрээс нь энэ станцыг ингээд өргөтгөхтэй холбоотой, түүхий эд буюу нүүрсийг энэ станц руу авчрахтай холбоотой, дэд бүтцийг сайжруулах шаардлагатай болно. Энэ бүх ажлууд нь энэ зураг төслийн хүрээнд хийгдэх үү? Тэгэхээр энэ энэ гэрээн дээр яг тодорхойгүй байгаа юм байна л даа. Энэ бол ерөнхийдөө гэрээ хийхийг зөвшөөрөл олгосон тийм л гэрээ юм шиг харагдаад байна л даа. Тэгэхээр энэ дээр хариулт бас өгөөч ээ гэж.

Р.Сэддорж: Чойжилсүрэн сайд 4 номер.

Б.Чойжилсүрэн: Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Энхцэцэг гишүүн ээ, эхний ээлжид байна шүү дээ, ОХУ-тай ТЭЦ 3-ынхаа өөрийнх нь зураг төслийг боловсруулах ийм Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулж байгаа юм, нэг. Таны асууж байгаа асуулт зүй ёсоор ургаж гарна. Энэ асуудлууд бид нар ингээд зураг төсөл юу боловсруулах энэ Засгийн газрын хоорондын хэлэлцээрийг ОХУ талаасаа ч тэр, Монгол Улс талаасаа ч тэр, соёрхон батлаад хүчин төгөлдөр болсны дараа Интер РАО Экспорт компани ТЭЦ 3-ын хооронд гэрээ байгуулагдана. Зураг төсөв боловсруулаад 2 жил болох байх гэж ийм баримжаатай байгаа. 2025, 2026. Магадгүй эцсийн төлбөр нь 2027 онд өгөхөөр ТЭЦ 3-аас 20 орчим сая доллартой багтаагаад зураг төсөв боловсруулна гэсэн ийм урьдчилсан төлөвлөлттэй явж байгаа. Зураг төсөв бол зураг төсөв хийгдсэний дараа эцсийн үнэ тодорхой болоод ОХУ, Монгол Улсын Засгийн газар хооронд хэлэлцээр дараагийн шатны барилга угсралтын гэрээ байгуулагдсан тохиолдолд таны ярьж байгаа хуваарилах байгууламжууд дээр холбогдох өөрчлөлтүүдийг оруулж таарна.

Тийм учраас тухайн үед нь бид нар энэ төсөл явах эсэхийг харж байгаад тухайн үед өргөтгөх хэсгээр өргөтгөх эсэх асуудлыг шийднэ. Энэ хэлэлцээрт энэ хуваарилах байгууламжуудын өргөтгөл ороогүй.

Р.Сэддорж: Цогтгэрэл гишүүн. Хассуурийн Ганхуяг гишүүнийг нэмээрэй.

О.Цогтгэрэл: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Түрүүн танилцуулга дээр 3 дугаар цахилгаан станцын суурин дээр гэдэг үг гарч байна лээ. Тэгээд суурин дээр гэдгээс хамаараад 1, 2 асуулт асуух гээд байна л даа.

1 дүгээрт нь, суурин дээр нь барих юм бол энэ чинь бараг шинээр барих асуудал юм шиг байна. Аль эсвэл зэрэгцүүлж барих гэж байгаа юм уу? Шинээр барих гэж байгаа бол энэ заавал Орос биш, ер нь яагаад Орос гэж байгаа юм? Өргөтгөл биш шинээр барих гэж байгаа бол ер нь энэ Оросын технологи чинь өөрөө яг ямар түвшинд байдаг юм? Адил хэмжээний хүчин чадалтай Оросын станц бараг 1400, манай 4 дүгээр цахилгаан станцад 1400 хүн ажилладаг ийм хэмжээний нүүрсний станцад чинь 100 хүн ажилладаг болчихсон гэсэн. Тэгээд жишээд хэлэх юм бол Уаз 469 машиныг Япон жипийн үнээр авах гэж байгаа юм шиг хуучин тийм зүйл яригдаж байсан. 300 мвт нь 1,3 тэрбум евро ч гэлүү, мегаватт нь үндсэндээ бараг 4, 5 сая долларын асуудал яригдаж байна лээ.

Тэгэхээр энэ ер нь яагаад яг суурин дээр нь шинээр барих гэж байгаа бол яг яагаад Орос гэдэг тал руу ингээд технологийн ийм хоцрогдолтой орон руу хоригт орчихсон. Мэдээж энд чинь нарийн технологийн чип зэрэг олон олон зүйлүүд энэ дээр яригддаг байх. Яагаад Орос гээд явчхав аа? 1 дүгээрт.

2 дугаарт нь, дахиад суурин дээр нь барина гэдэг чинь хуучныг нь ашиглахгүй юм байна. Буулгаж байгаад магадгүй барих юм байна л даа. Манай бид нарын нөгөө алдарт Дарханы замын чинь 2 дугаар хувилбар энд гарах юм биш үү? Хуучин замаа хуулаад хаячихдаг. Тэгээд 4, 5 жил шороогоор явдаг. Нөгөө шинэ зам маань ашиглалт байдаггүй. Тэгэхээр энэ зөвхөн суурин дээр гэдэг үгний чинь цаана л лав 2, 3 ийм нюанстай зүйлүүд харагдаж байна л даа. Тэгэхээр эдгээрт хариулт өгөөч?

Р.Сэддорж: Хассуурийн Ганхуяг гишүүнийг нэмээрэй. Сайд хариулах уу? 4 номер Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Цогтгэрэл гишүүн ээ, ийм түүхтэй юм байна лээ. 2019 онд Монгол Улсын Ерөнхий сайд ОХУ-д айлчлах үеэр, ОХУ-ын Ерөнхийлөгч энд ОХУ-ын талаасаа, бид нар Монголоор дамжуулаад хий дамжуулах хоолой барина, Хятад руу. ТЭЦ 3-ыг манай ОХУ-ын технологиор бид нар барьж өгсөн. Хуучин Зөвлөлт холбоот улс энэ өргөтгөл шинэчлэлийн төслийг Оросын компаниудын дунд зарлаач ээ гэдэг ийм санал тавиад энэ асуудал тэр 19 оноос хойш яригдаад явсан юм байна лээ, 1.

2 дугаарт, энэ станц бол, та зөв ойлгосон байна. Энэ 2 үе шаттай юм болно. Эхний 1 дүгээр үе шат нь одоо байгаа захиргааны барилгынх нь нэг хэсгийг буулгаад 50 мвт-ын хүчин чадалтай турбин суулгана. Цахилгааны хувьд. 100 гега кил калори цагийн хүчин чадалтай юу зуух суулгана. Ингээд 1 дүгээр үе шат нь ийм болно.

Үүний дараа одоо байгаа 4-ийг үржих 12 мвт-ын 4 турбин бий. Холбогдох дулааны юу зуухтайг нь ашиглалтын хугацаа дуусчихсан, бид нар явж байгаа одоохондоо зүгээр ингээд ямар ч байсан ашиглаад явж байгаа. Үүнийг хүссэн хүсээгүй буулгах шаардлага үүснэ. Энэ 4 дунд даралтын юу нам даралтын гэж ярь нэрлэдэг 4-ийг үржих 12мвт-ын 4 12-ын турбин холбогдох зуухнуудтай хамт буулгаад, 2-ыг үржих 125 мвт-ын 2 турбин 300, 400 гега кил калори цаг юм. Дулааны зуухнуудын хамт шинээр суурилуулдаг гэсэн үг. Яг бодит байдал дээр бол 2 шинэ станц гэсэн үг. Эхнийх нь 50 мвт-ын цахилгааны хүчин чадалтай 100 гега кил калори цагийн хүчин чадалтай, юу дулааны хүчин чадалтай 1 дүгээр станц, 2 дугаар станц нь 2-ыг үржих 125 мвт-ын хүчин чадалтай 250 мега ваттын хүчин чадалтай

цахилгаан юу 400 гега кил калори цагийн хүчин чадалтай дулааны эх үүсвэрүүдийг 2 шинэ станц гэсэн үг. Ийм байдалтай байгаа.

3 дугаарт, тэр 2019 он, 2021 онууд дээр хийсэн ОХУ-тай хийсэн уулзалтуудын үеэр яг өнөөдрийн байдлаар бодит байдал дээр нүүрсний төсөл рүү мөнгө юу босгох бол эх үүсвэр бас санхүүжилт босгоход тун хүндрэлтэй байна. 2019 оны Парисын хэлэлцээр, 2021 оны НҮБ-ын чуулган дээр Хятад улсын дарга Си Жиньпин даргын мэдэгдлүүд, Хятадын холбогдох төрийн шийдвэрүүдээс шалтгаалаад 15 оноос өмнөх нөхцөл байдалтай хөрөнгө босгох бололцоо бол бараг 90 орчим хувиар уначихсан нь ийм хүндрэлтэй байгаа учраас ийм шийдвэрийг гаргасан юм байна лээ.

Би 2022 оны 8 сарын 30-ны өдөр Эрчим хүчний сайдаар энэ түрүүчийн Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд томилогдоод очсоны дараа, 9 сарын 10-аар байх, энэ ТЭЗҮ-г боловсруулаад, Оросын тал Монгол улсын ЭХЯ-нд Интер РАО компаниас ТЭЦ 3 болон ЭХЯ-нд ТЭЗҮ хүлээлгэж өгсөн иймэрхүү байдалтай байгаа.

Р.Сэддорж: Цогтгэрэл гишүүн тодруулга.

О.Цогтгэрэл: Харин тийм. Тэгэхээр та бас яг л бодит байдлыг л хэлж байна л даа. Энэ чинь ингээд буулгаж байгаад шинээр барих юм байна шүү дээ. Тэгэхээр яагаад заавал Орос юм бэ? Оросыг өргөтгөх биш, тэр газрыг ашиглаад бараг дэд бүтцийг ашиглаад, шинээр барих гэж байгаа юм бол илүү технологийн дэвшилтэт технологитой, хүчин чадал өндөртэй, ашигт үйлийн коэффициент өндөртэй, хориг саадад ороогүй улстай яагаад энэ ажлаа бид нар 1 дүгээрт нь ярьдаггүй юм бэ л гэхээр хариулт бас жаахан тодорхой биш л байгаад байна л даа.

2 дугаарт нь, энэ станцыг чинь буулгаад хаячихаар тэр тусмаа дулааны эх үүсвэр, цахилгааны болоод дулааны эх үүсвэр гэдгийг нь яг хотын төвд байгаа наад станц дээр чинь дулааны үйлдвэрлэх хүчин чадал нь их ашиглагддаг байх. Тэгээд дулаан энэ Улаанбаатар хотод чинь дулааны болоод эрчим хүчний дутагдалд орчих юм биш үү? Одоо байгаа хомсдолд орчихсон байгаагаа буулгаж байгаад 4, 5 жил. Дахиад нөгөө алдартай Дарханы замын араас наадах чинь ороод бүр ингээд юун өргөтгөл, шинэчлэл сайн сайхан юм биш. Одоо байгаа энэ дулааны эх үүсвэр олон олон зүйл чинь бүр нохойн замаар орох юм биш үү наадах чинь, ер нь.

Р.Сэддорж: Чойжилсүрэн сайд тодорхой хариулъя.

Б.Чойжилсүрэн: Цогтгэрэл гишүүн юу, бас болгоомжилж байна. Зөв байх. Тийм учраас энэ төслийг 2 хуваасан юм байна лээ. Эхлээд тэр нам даралтын хэсгийг буулгахгүй байж байгаад үйлдвэрлэж байгаа 48 мвт-ынх нь оронд 50 мвт-ын цахилгаан, одоо байгаа тэр 48 мвт-ыг дагалдах зуухнууд нь 100 гега кил калори цагийн хүчин чадалтай байгааг шинээр барьчхаад, тэр өөрийн чинь болгоомжлоод байгаа дулааны дутагдалд оруулахгүйн тулд эхлээд нэг жижгээр барь, энэ жижиг станцыг нь барьчхаад, дараа нь 2 дахь ээлжид нь тэр юу тэртээ тэргүй хугацаа нь дуусчихсан буулгах юу энэ станцын суурин дээр 2-ыг үржих 125 мвт-ын хүчин чадалтай шинэ станц барья гэж, нэг ийм шийдвэр гаргасан юм байна.

2 дугаарт, би сая танд хэллээ шүү дээ. Санхүүжилт босгоход магадгүй ОХУ ер нь цөөхөн үлдсэн эх үүсвэрийн нэг учраас ОХУ-аар бариулъя гэдэг шийдвэрийг

ОХУ-ын юу талтай төрийн өндөр албан айлчлалын үед хэд хэдэн удаа шийдвэр гаргаад энэ хэлэлцээр ... /минут дуусав/

Р.Сэддорж: Гүйцэж хариулъя, Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: ОХУ-ын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газрын хооронд ийм шийдвэрүүд, улс төрийн шийдвэрүүд нь гараад одоо ингээд явж байгаа юм байна лээ.

Р.Сэддорж: Баярлалаа Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Баярлалаа. Хоёрхон асуулт байна.

1 дүгээрт, энэ маань 1,5 тэрбум еврогийн өртөгтэй тийм том төсөл байна шүү дээ. 1,5 тэрбум евро. Тэгээд 85 хувийг нь ОХУ-ын экспортын зээлээр санхүүжүүлнэ гэжээ. Тэгээд ер нь ОХУ-ын зээлийг л бид нар авах гэж байгаа юм байна. Тэгэхээр үүнийгээ Чойжоо сайд юу яаж болоогүй юу, нөгөө нэг Эгийн голынхоо УЦС-тай уяж, нэгэнт бид нар ийм том өртгөөр илүү өндөр өртөгтэй станцыг барих гэж байгаа юм чинь, шахуулж л байгаа юм байна гэж би ойлгож байна. Ер нь бол. Эгийн голынхоо УЦС-тай холбож явуулж болоогүй юу гэсэн нэгд ийм санал байгаа юм.

2 дугаарт, энэ зээлийн хэлэлцээрийг ингээд уншаад үзэхээр дотор нь бүх тоног төхөөрөмжөө ОХУ-аасаа авна гэсэн байгаа байхгүй юу. Тэгээд нөгөө Орос улсад маань ийм хэмжээний орчин үеийн технологи энэ тэр байна уу, үгүй юу? Нөгөө 1960 онд хийгдсэн Боховка гэдэг нэртэй фургон чинь 60 жилийн дараа яг хэвээрээ байгаа шүү дээ. Тэгэхээр ийм тийм технологи байгаа юу гээд манай энэ ЭХЯ-ныхан судалж үзсэн юм болов уу? Ийм 2 л асуулт байна.

Р.Сэддорж: Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Алдаржавхлан гишүүн 1,5 тэрбум биш, 1 тэрбум 326 сая еврогоор барья гэсэн ийм саналыг ирүүлсэн. 2022 оны 9 дүгээр сард. Бид ийм өндөр үнээр авч чадахгүй ээ, бариулж чадахгүй ээ гэдэг ийм саналыг тавьж байгаа юм, Оросуудад зөрүүлээд. Тэгэхээр Оросууд зөрүүлээд тэгвэл та нар зураг яг ажлын зураг төсвөө хийчхээд юуг нь тохиръё, үнийг нь тохиръё гэдэг ийм санал тавьж байгаа юм. Бидний хувьд үүнийг 814 сая доллароос евро биш шүү, доллароос илүү өртгөөр бариулж чадахгүй гэдэг ийм 2 талаасаа тулчхаад л байж байгаа юм.

Тийм учраас Эгийн голын УЦС-тай ямар нэг байдлаар холбохгүй байгаа, шахаа авахгүй гэж бодож байгаа. Яг энэ ОХУ-д энэ экспортын зээл ганц ОХУ биш бүх экспортын зээлүүдийн нөхцөл нь бол хүү дээрээ, хугацаа дээрээ хөнгөлөлттэй, татаастай байдаг учраас тухайн улсынхаа өөрийнхөө бараа бүтээгдэхүүнийг юу түлхүү, зөвхөн тэр улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хэрэглэнэ ээ гэсэн ийм нөхцөлүүдийг тавьдаг. Ганцхан энэ ОХУ биш, экспортын зээл. Хугацаа нь бол урт хугацаатай, хөнгөлөлттэй татаастай ийм хүү дээр нь татаастай ийм зээл. Бүх эксимүүдийн зээл ийм л байдаг. Үүний дагуу л явж байгаа юм.

Тэгэхээр одоо бид нар яагаад энэ 2 тасалж оруулж байж, энэ удаа бол зөвхөн зөвхөн зураг төсвийг боловсруулъя. Үүний дараа үнэ тохирвол барилга угсралтын

ажил гэрээ байгуулах тухай ярина. Тэгэхгүй бол гэрээ байгуулагдахгүй гэсэн үг. ОХУ-д ийм тоног төхөөрөмжүүд байна уу гэж байна, байгаа юм байна лээ.

Р.Сэддорж: Алдаржавхлан гишүүн тодруулга.

Ж.Алдаржавхлан: Хэрвээ зөвхөн зураг төсвийн шатандаа явж байгаа бол ийм нэг санал байх юм. Одоо ч өнгөрсөн байх л даа, ярихад. Бид нар ийм төвлөрсөн системээсээ илүү нэг хэсэгчилсэн систем рүү шилжье гээд байгаа шүү дээ. Монгол Улс чинь ер нь ийм нэг том төвлөрсөн ганц станцаас бүгдийг хангахаа болиод жижиг жижиг хөөрхөн станц руу шилжье гэсэн энэ чиглэл рүү төсвөө, төслөө шилжүүлэх юу санал санаачилга байгаа юу, эсвэл оройтсон уу? Үүнийг нэг хамгийн сүүлд нь хариулт авчихъя.

Р.Сэддорж: 4 номер.

Б.Чойжилсүрэн: Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. ТЭЦ 3 маань яг Улаанбаатарын дулаан хангамжийн тухайд бол хамгийн стратегийн байрлал дээр байгаа. Хотын төв, зүүн хэсэг рүү, бараг Зүүн 4 зам руу. Цаашаа юу ТЭЦ 3-аас явж байсан. Өнгөрсөн жилүүдэд бид нар Амгалан дулааны станцыг ашиглалтад оруулаад ямар ч байсан зүүн 4 замаас зүүн тийшээ Амгалан дулааны станц руу явж байгаа юм. Магадгүй бид нар нөгөө Амгалан дулааны станц дээр нэг 400 мвт-ын дулааны төсөл дээр ТЭЗҮ газар хаагаад явж байна. Хийчих юм бол бид нар Их дэлгүүр хотын төв хүртэл зүүн талаасаа хангачих байх, ер нь.

Тийм учраас үүнийг дулааны ч хэрэг юу, хамгийн алтан байрлал дээр байгаа Улаанбаатар луу нөгөө төмөр замын дэд бүтэцтэй. Усны асуудал шийдэгдсэн нэг ганц байрлал учраас ТЭЦ 3 дээр үүнийг зайлшгүй барихаас ондоо аргагүй байгаа.

Таны яриад байгаа тэр тархмал эх үүсвэрийг бид нар барина. Барихдаа тархмал эх үүсвэрээс үйлдвэрлэсэн ... /минут дуусав/

Р.Сэддорж: Сайд гүйцээж хариулъя.

Б.Чойжилсүрэн: Дулааны станц бол үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь манай Амгалан дулааны станц дээр 1 гега кил калори цаг нь 95000-100000 орчим төгрөг байна. Сэлбэ дэд төв гэх мэт жижиг чадалтай станцууд дээр бүр 125000 байгаа юм. Тэгэхээр энэ 125000-ыг орон сууцын метр квадратад шилжүүлэх юм бол 1 м2-ын сарын төлбөр 2505 төгрөг болчих гээд байгаа юм. Гэтэл өнөөдрийг бид нар 506 төгрөг байгаа учраас ТЭЦ 3, ТЭЦ 2, ТЭЦ 4 дээр үйлдвэрлэсэнд юу эрчим хүчний дулааныг нэг 65000 гега кило калори цаг нь өөрийнх нь өртөг нь. Ингээд бодохоор дундажлаад хөндлөн татаас өгөөд дулаан дээр нь нэг худалдан авагчдын загвар бий болгоод энэ тархмал эх үүсвэрүүдийг 80000 айлын орон сууцыг ашиг юу хүртэл орон сууц дээр татаас өгье гэдэг ийм шийдвэр гаргаад явж байгаа ийм л асуудал байгаа юм. Энэ ТЭЦ 3-ын өргөтгөлийг зайлшгүй дулааны хувьд ч тэр ... /минут дуусав/

Р.Сэддорж: Ганзоригийн Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Улаанбаатар хотод, Улаанбаатар гэлтгүй улсын түвшинд дулааны эрчим хүч, цахилгааны эрчим хүчний нийлүүлэлтийн дутагдалтай байдал маш хүнд байгаа

гэдгийг ойлгож байна. Энэ бол хэрэгтэй төсөл гэдгийг маш сайн ойлгож байна. Гэхдээ ийм нэг хөгжиж байгаа орнуудыг том гүрнүүд дээрэлхэж байгаа юм шиг цаанаас нь шууд хийлгэх компанийг нь зааж өгөөд, ийм өндөр өртгөөр төсөл хийлгэнэ ээ гээд ороод ирдэг. Хэрэгцээтэй байгаа нь үнэн л дээ. Гэхдээ энэ аманд нь ороод байгаа тийм зүйл байгаа юм уу, үгүй юм уу. Одоо энэ зураг төслийг нь Интер РАО Экспорт гэдэг компани өөрөө хийх гэж байгаа юм уу. Энэ танилцуулга дээр харахад шууд Оросын талаас энэ компанийг л сонго гэсэн тийм заалт өгч байна шүү дээ, тийм ээ. Энэ чинь сонгон шалгаруулалт гэдэг юм байгаад, өрсөлдөөн байгаад, аль технологи нь илүү юм, аль компани нь илүү хариуцлагатай байх юм. Манай ДЦС 3 компани хамтарч ажиллахад аль нь эвтэйхэн юм гэсэн олон улсын төсөл, хөтөлбөр чинь нэг хоорондоо харилцан яриа болоод, тэгээд шийдэгддэг зүйлүүд болов уу гэж бодоод энэ ингээд шууд тулгаж байгаа юм шиг харагдаад байна л даа. Энэ нөхцөл байдал яг ямар байгаад байгаа юм.

Тэгээд бас энэ 1,5 тэрбум еврогийн зээл шүү дээ, тийм ээ, манай талаас рублийн зээл болгоё гээд санал тавьсан байна. Өмнөх уулзалтаар та үүнийг рублиэр болгоё гэсэн санал тавихад Оросын тал ямар хариу өгч байсан бэ? Ер нь цаашдаа үүнийг рубль болгох боломж байна уу? Яагаад Орос Монгол 2 хоорондоо зээл хийгээд, гэрээ хийгээд төсөл хэрэгжүүлж байхад заавал еврогоор тооцоо хийх ёстой байдаг юм. Манай улсад бол рублиэр хийсэн нь илүү эвтэйхэн шүү дээ.

3 дахь нь асуулт нь болохоор энэ үйл ажиллагааны хэрэгжүүлэх дараалал нь байгаад байна. Их эвгүй. Эхний ээлжид захиргааны барилгыг буулгаж байгаад 50 мвт-ыг барина. Дараа нь 48-ыгаа буулгаад дараа нь 205-ийг барина гээд. Тэгэхээр нийлүүлэлт бол нэг 2 мвт-аар л нэмэгдэхээр л байгаад байна. Шууд анхнаасаа, энэ шууд 100 мвт-аар нэмчхэж болдоггүй юм уу? Тэгэх юм бол бид нарт үнэхээр ингээд тулгамдаад байгаа юм чинь 100 мвт-аар эхэлж бариад, дараа нь 48-ыгаа буулгаад дараа нь 150 мвт барьдаг ч юм уу. Ийм сонголт байсан уу? Хэдэн төрлийн сонголт гаргаж байгаад, тэд нарыгаа харьцуулаад, энэ хамгийн зөв юм байна гэсэн тийм сонголтлоо яаж хийсэн тэр логикоо тайлбарлаж өгнө үү гэж хүсэж байна. Тэгээд дараа нь тодруулга дээр зураг төсөлтэй холбоотой 2 асуулт нэмж асууя.

Р.Сэддорж: Чойжилсүрэн сайд хариулъя, 4 номер.

Б.Чойжилсүрэн: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Манайх хоёрхон хөрштэй шүү дээ. ОХУ, Хятад улстай. ОХУ-аас заавал үүнийг хэрэгжүүлье гэж тулгаад байгаа ч юм байхгүй. Манай талаас хүсэлт тавьсан юм байна лээ. Оросууд та нартай хамтраад хэрэгжүүлье, экспортын зээл өгөөч гэсэн юм байна лээ. Экспортын зээл өгөхөөр өөрийнхөө тухайн улсынхаа, өөрийн компаниудын дунд тендер зарладаг. Хятадын Эксим банкны экспортын зээл бол Хятадын компаниудын дунд, Солонгосынх бол Солонгосынх, Америкийнх бол америкийнх. Оросынх бол Оросынх энэ жишгээрээ л явж байгаа юм байна лээ.

Тэгэхээр 1 аманд нь ороод байгаа юм байхгүй, бидний байгаа царай энэ. Төсөв дээрээ хуримтлалтай байсан бол хүнээс ингэж мөнгө гуйгаад яах вэ. Өөрийнхөө мөнгөөр барьчих ёстой байхгүй юу. Мөнгө байхгүй, хуримтлал байхгүй. Гэтэл хэрэглээ маань өсөөд байгаа учраас ийм байдалд орчихсон.

2 дугаарт, рублиэр зээл авч болох уу гэж та асуулаа. Би бол рублиэр зээл авъя гэж нэг бодож байснаа гэхдээ их төвөгтэй зүйл. Санхүү талаас нь аваад үзэх юм бол рубль ч тэр, ОХУ өөрөө хөгжингүй орон биш, Хятад улс ч хөгжингүй орны

ороогүй байгаа, манайх ч гэсэн ороогүй байгаа. Тэгэхээр энэ нөгөө Хятад бол харин эсрэгээрээ нөөцийг нь юанийн нөөцийн валютад оруулж чадсан. Эдийн засгийн макро түвшнээ 10, 20, 30 жилээр урьдчилан таамаглаж болохуйц байдалд удирдаж чаддаг энэ тогтвортой эдийн засаг тогтвортой валютад хүмүүст юу баримжаалж урьдчилан тооцоолол хийнэ. Би бол Сангийн сайд байсан хүний хувьд рублиэр хийхэд бас янз бүрийн эрсдэлүүд гарч ирэх юм байна лээ.

Тийм учраас би энэ аль нэг нөөцийн валютаар тохирчихсон нь илүү тодорхой, илүү урьдчилан таамаглаж болохуйц илүү эрсдэлгүй болох болов уу гэсэн ийм байр суурьтай байдаг хүн. Тийм учраас энэ юу аль нэг юу юугаар тохирно оо. Нөөцийн валютаар тогтвортой валютаар тохирохгүй бол энэ их олон төрлийн савлагаа болно. Заримдаа та мэдэж байгаа шүү дээ, 60 болж байсан 1 доллар, рубль 60 байж байснаа 120 болдог, 80 болдог, 90 болдог, заримдаа 40 болдог. Энэ чинь их барьцгүй манай төгрөгтэй л адилхан ийм үнэлгээнд эрсдэлийн үнэлгээ нь ийм байгаа учраас би бол нэг тийм нөөцийн валюттай, олон улсын санхүүгийн хүлээн зөвшөөрөгдсөн. Маниусыг бодоход эдийн засгаа удирдан тогтвортой макро юу тэнцвэрүүдээ хадгалж чаддаг ийм улс орны валютаар хийвэл зүгээр юм болов уу гэсэн ийм тооцоолол байгаа.

Яагаад үүнийг юу 50 мвт-ыг 100 мвт болгож болсонгүй вэ гэсэн ийм асуулт тавилаа, та. Байгаа газрынх нь хэмжээнд энэ оновчлолыг юу хийсэн юм байна лээ. Манай ЭХЯ-ныхан, ТЭЦ-ынхан, энэ Интер РАО компанийнхан хэд хэдэн хувилбар сонгож байгаад үүнээс ондоо бололцоо байхгүй. Байгаа боломждоо хүчин чадлыг нь тулгаад хийчихсэн ийм л зүйл ... /минут дуусав/

Р.Сэддорж: Сайд гүйцээж хариулъя.

Б.Чойжилсүрэн: Тийм ээ, зураг төсвийг Интер РАО компани боловсруулна. Интер РАО компани зураг төсөв боловсрогдсоны дараа эцсийн үнэлгээ дээр тохирч чадвал санхүүжилтийн гэрээ, барилга угсралтын гэрээний тухай яригдана. Тэгж чадахгүй бол бид нар энэ шатандаа ажил зогсоно гэсэн үг.

Р.Сэддорж: Лувсанжамц гишүүн тодруулга.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Миний нөгөө эхний асуулт нь болохоор нөгөө Орос дотроо яах вэ, орос компани сонгоно гэж шаардлага тавьж байгаа нь бол зөв л дөө. Угаасаа тэгдэг, олон улсын жишиг нь тийм. Ялангуяа ийм дээрэнгүй их гүрнүүд тэгдэг юм. Харьцангуй гайгүй улсууд бол нэг олон улсын тендер зарлаж байгаад гаднын компани ч гэсэн оруулах боломжийг нь бүрдүүлж байгаад захиалагч талынх нь дуу хоолойг нь бас сонсож байгаад шийддэг л дээ. Орос хойд хөрш бол тэгэхгүй л байх. Энэ Интер РАО-оос өөр компани тэр дотоодынх нь тендерт нь орсон юм болов уу гэсэн асуулт байсан л даа. Байж байгаарай.

Тэгээд зургийн ажил хийх дээр нь бас асуулт байна. Одоо бид нар зураг төслөө боловсруулна, Интер РАО хийж өгнө өө гэж байгаа тийм ээ. Энэ ажлын даалгаврыг хэн боловсруулж байгаа вэ. ДЦС 3 өөрсдөө боловсруулсан орж ирнэ үү?

Дараа нь зураг төслийн ажил эхлэх үед захиалагчийн хяналт гэдэг юм цуг явах ёстой. Энэ захиалагчийн хяналт гэдэг зүйлийг ямар байгууллага хийх гэж

байгаа вэ? Та бүхэн өөрсдөө хийх гэж байна уу, эсвэл гуравдагч хариуцлагатай дараа ... /минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт 4 номер.

Б.Чойжилсүрэн: Ажлын даалгаврыг Монголын тал боловсруулж байгаа. ТЭЦ 3 боловсруулаад манай ЭХЯ-наас бид нар бодлогын дэмжлэг үзүүлж байгаа, 1.

2 дугаарт, энэ зураг төсөв бол Монголын өмч болж үлдэнэ. Энэ барилга угсралтын гэрээн дээр тулахгүй ч гэсэн.

3 дугаарт, Монголын талаас бид нар магадлал хийнэ. Манай Эрчим хүчний хөгжлийн үндэсний төв олон улсын байгууллагуудтай ийм асуудал байсан.

Хэрвээ ОХУ-тай бид нар нөхцөл үнэ тохироод яриад явах юм бол тусад нь бид нар тендер зарлах ёстой. Энэ юу хяналтын зөвлөх үйлчилгээ дээр нь тусад нь тендер зарлана, олон улсын чадавхтай компаниудын дунд.

Р.Сэддорж: Болчихсон шүү дээ. Тийм, болчихсон. Хариулт хангалтгүй гэж үзэж байгаа юм уу? Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Бас нэг асуулт байсан. Нөгөө 1,5 тэрбум еврогоор энэ ТЭЦ 3-аас асууж байгаа асуулт шүү. Манайхан өөрсдөө хийх юм бол тал үнээр нь шахуу. Барих хугацааг нь ч гэсэн 2 жилийн хугацаагаар богиносгох боломжтой гэсэн танилцуулга дээр байна л даа. Үүнийг манай ТЭЦ 3 юу гэж бодож байгаа юм бол?

Р.Сэддорж: 4 номер хариулт.

Б.Чойжилсүрэн: Яг ийм учраас Лувсанжамц гишүүн ээ, ийм өндөр үнээр одоо залуучуудын хэлдгээр шагай авахгүй ээ, буулга аа гээд. Буулга гэхээр тэгвэл зураг төсөв ирээд хийчихье. Бүх туслан гүйцэтгэгч нарын хооронд тендерээ зарлачихъя. Тодорхой болгочихъё гэдэг ийм саналыг Интер РАО-д Оросын талд тавихаар нь бид нар тэгвэл зураг төсвийг хийгээд үзье ээ гэдэг ийм зүйл дээр л явж байгаа юм. Таны болгоомжилж байгаа тэр яриад байгаа бидний танилцуулгаа Улсын Их Хурлын гишүүд олон нийтээс нуух шаардлага алга байна. Ийм өндөр үнээр ийм гэрээг би Эрчим хүчний сайд байх үедээ хийж чадахгүй ээ, хийхгүй.

Р.Сэддорж: Жаргалан гишүүн үгээ буцааж байна. Сайнзориг гишүүн байхгүй байна. Хассуурийн Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Өглөөний мэнд хүргэе. Тэгээд яах вэ, нэг 2 л асуудал асуух тодруулах гээд байгаа юм. Сая 2, 3 хоногийн өмнө Нямбаатар даргын бас ярилцлагыг үзсэн л дээ. ТЭЦ 2-ын хашаанд 300 мвт-ын цахилгаан станц барина гээд. 670 сая доллароор барина гэж байна лээ, нураагаад барихад. Тэгэхээр бид нар өндөр хөгжилтэй орны технологиор тийм хэмжээний үнэ өртгөөр барих гээд байна шүү дээ. Тэгэхээр манайх чинь Оросоос гэхээр нэлээн л хоцрогдсон үеийн технологи л авах болов уу даа л гэж бодох юм. Тэгээд үнэ өртөг, өгөх үр өгөөж, ер нь тэрийгээ харьцуулбал тийм зөв хөрөнгө оруулалт байж чадах уу, үгүй юү? 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт. Энэ гэрээ хэлэлцээр хийнэ гэдэг чинь уг нь манайх тэднийд бас бизнес өгч байна шүү дээ. Ингээд манайд ирээд бизнес хийнэ гээд. Эндээ юмаа барья гээд. Тэгэхээр манайх эргээгээд яг энэ гэрээ хэлэлцээрээ юу олж авах юм бэ л гэдэг л сонин байна л даа. Сая энэ Алдаржавхлан гишүүн бас зөв л санаа хэлж байна шүү дээ. Ядаж Эгийн голынхоо станцын төслөө ярьж болоогүй үгүй юу. Юм чинь ер нь өгөө овоотой л байх ёстой шүү дээ. Дандаа ингээд манайх өгөөд л байдаг байж бас болохгүй шүү дээ. Тэгээд энэ дээр та бүхний байр суурийг сонсчихмоор байх юм.

Р.Сэддорж: 4 номер Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: ТЭЦ 2-ын тухайд одоо Улаанбаатар хот руу тэр төмөр замтай бас усныхаа асуудал ч шийдчихсэн 2 дахь байрлал нь ТЭЦ 2. Үүнийг ТЭЦ 2-ын захиалгаар би 2022 онд сайд болсныхоо дараа энэ ТЭЗҮ-г хийлгэсэн. Яг ТЭЦ 3 дээр явж байгаа төсөлтэй адилхан ийм чадалтай байгаа. Одоо энэ төслийн И Кю Тиг нөгөө өөрийн талын санхүүжилтийг нь ЭХЯ шийдэж чадахгүй байгаа учраас энэ төслийг нийслэл рүү шилжүүлж өгөх гэж байгаа юм. ТЭЦ 2-ын газрын үнсэнд үнсний талбай байгаа хэсэг газрыг одоо ингээд удахгүй Улаанбаатар хот руу шилжүүлж өгөөд, юу саяын ярьсан Нямбаатар даргын энэ төслийг юу Улаанбаатар хот руу шилжүүлээд та нар хэрэгжүүлэх гээд оролдоод үз ээ. Бид ойролцоогоор нэг 700 орчим сая доллар болох болов уу гэсэн ийм баримжаа байгаа. Хятадын тоноглолоор хийх юм бол. Тэрний нэг 40 орчим хувийг нь заавал эргэн төлөгдөхгүйгээр өөрийн хөрөнгө оруулалт хийхгүй бол 60 орчим хувиас энэ өөр Энэ манай одоо байгаа тарифаар зээлээ эргэн төлж чадахгүй болчихоод байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ хот руу шилжүүлж өгч байгаа юм. Тэгээд энэ 2 станц яг эрдэнэ чадалтай учраас ер нь тодорхой болно. Бид нар ямар ч байсан ТЭЦ Оросууд маань Оросууд яриад байгаа, бид нар Хятад технологиор явах юм бол энэ чинь нэг ийм үүнээс дээшээ гарахгүй байна гэдэг ийм зүйл яриад байгаа учраас Оросуудыг бид нар энэ зураг төсвөө хийчхээд, дараа нь үнийн тухай ярья. Санхүүжилтийн нөхцөлийн тухай ярья. Барилга угсралтын цаг хугацааны тухай ярья гэдэг ийм асуудал аргагүйн эрхэнд 2 хуваачхаад байгаа байхгүй юу. Энэ төслийг бол таны асуусан Эгийн голтой шууд холбож хэрэггүй байх. ОХУ чинь бид нар мөнхийн хөрш өө. ТЭЦ 3 дээрээ асуудал дуусаагүй байхад дахиад ТЭЦ 2-той юу Эгийн голтой аваачиж үүнийг холбох бол улс төрийн хувьд 2 улсын харилцааны хувьд ч дэмий болов уу гэж бодож байна. Төсөл төслүүд нь тус тусдаа байвал зүгээр байх гэж бодож байгаа. Аль нэг төслийг хэрэгжүүлэхийн тулд нөгөө төслөөр нь татаас өгөх ийм байдлыг Засгийн газар баримтлахгүй байгаа.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Алга байна.

Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: ТЭЦ 3-ынхандаа л хандаж үг хэлмээр байна л даа. Өмнөх бас Эдийн засгийн байнгын хороо дээр Эрчим хүчний зохицуулах хорооноос манай эрчим хүчний салбарын стратеги төлөвлөгөө гарах ёстой гээд тэгж байсан. Түүн дээр хэлэхдээ төрийн өмчит компаниудын менежментийн шинэчлэлийг бас хийх

ёстой гээд. Бид нар сая цахилгаан дулаан, цахилгааныхаа үнийг нэмсэн. Цаашдаа дулааны үнийг нэмнэ гэж байгаа бол зөвхөн ард түмэн дээр буюу хэрэглэгч дээр ачааг үүрүүлэх биш, та хэд маань өөрсдөө менежментийн шинэчлэлээ хийгээд 1 квт цахилгаан гаргахын тулд зарцуулж байгаа зардал, хүний нөөцийнхөө зардлыг бууруулах боломж бололцоог өөрсдөө судлаад, Эрчим хүчний зохицуулах хороондоо хандаад, энэ олон улсын жишгээр бид нар ядаж нэг 3, 3 жилээр нэг салбарынхаа бодлогыг тодорхойлдог болох хэрэгтэй байгаад байгаа юм.

Аж үйлдвэрийн байнгын хороон дээр энэ төрийн өмчит компанийг 1, 1-ээр нь дуудаж энэ хэлэлцүүлэг хийгээд, цаашдын бизнес төлөвлөгөө буюу менежментийн шинэчлэлтийг хэрхэн сайжруулах юм бэ гэсэн танилцуулгыг сонсох төлөвлөгөөтэй байгаа. Энд та бүхэн маань бас боломжийнхоо хэрээр бэлдээд, дараагийн ирэх 3 жилийн ажлын төлөвлөгөө, менежментээ хэрхэн сайжруулах юм. Үнэ нэмсэн нөгөө тал дээрээ бид нар ингэж хичээнэ ээ гэсэн дүр зургаа тодорхой болгож ирэхийг хүсэж байна.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүнийг нэмье. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Уучлаарай дарга аа, би нөгөө Хууль зүйн байнгын хороо давхар хуралдаад, түүн дээр бас орж ирээд гээд болдоггүй. Тэгээд уг нь нэг 2 асуулт байсан юм. Би түрүүнд нөгөө Лувсанжамц гишүүн хөндсөн. Тэгэхдээ бид хэд аливаа улсын экспортын зээлийг авахдаа бас тодорхой нөхцөлүүдээ Монгол Улсынхаа эрх ашигт нийцүүлж авдаг юм. Ер нь Солонгос, Японоос авахдаа бид нар сонгон шалгаруулалтыг нь бид оролцоотой хийж болно. Зүгээр тэдгээр улсын компаниуд оролцож болдог байхгүй юу. Энэ бол үндсэндээ ингээд санал болгочихно л гэж байгаа юм. Би энэ дээр дурдагдаж байгаа өртгөөсөө ч илүү ТЭЗҮ зураг төсөв гараад ирэх вий дээ. Тэгээд 1 ийм л зүйл рүү зүгээр орж байна. Би яах вэ, зовлонг нь ойлгож байгаа. Энэ дээр нэг их эсэргүүцээд байх юм алга. Дутагдал байна.

Тэгэхдээ энэ эрчим хүчний асуудлуудыг, эрчим хүч дулааны асуудлыг шийдэхдээ бас л нэг энэ бид нарын зовлон дээр нэг ийм сонин юм болоод, энэ ч гэсэн цаашдаа энэ чиглэлд орж ирэх хөрөнгө оруулалтын багтаамжийг улам жижгэрүүлж байгаа юм. Энэ хэмжээний өртөгтэй зээлүүд. Бид хэд боломжийн зах зээл гэдэг юм уу бусад улсын боломжтой байдлаар зээл авахад иймэрхүү энэ гацаанууд цаашдаа үүснэ. Тэгээд жоохон тун харамсалтай байна.

Тэгээд ер нь зүгээр яах вэ, тодорхой энэ хэлэлцээрийн явцад энэ зураг төсөв ТЭЗҮ дээр ямар багцаатай байх энэ тэр урьдчилсан зүгээр юман дээрээ тооцохын тулд л ажлын даалгавар энэ тэр дээрээ маш сайн бас анхаармаар байна. Сүүлд нь бараг ингэж нэг ийм шийдвэр гаргуулж авчхаад, дахиад үнэ өртөг нь өсөөд ороод ирэх вий. Тэгээд ер нь зүгээр яах вэ, энэ дээр бас нэг болгоомжлол байна.

2 дугаарт, Чойжилсүрэн сайд аа, бас нэг өчигдөр нэг сэтгүүлч хөндөж байна лээ. Энэ эдийн засгийн хамгийн суурь зүйл болох эрчим хүч, энэ томоохон дэд бүтцийн төслүүдийг зогсоосон. Сая Туваан сайд маань үнэ өртгийг нь гаргаад ирсэн шүү дээ. Төмөр замыг зогсоогоод нийт энэ хугацаандаа бид нар 18,5 тэрбум доллар олж болох боломжоо алдсан байна гээд. Энэ эрчим хүчний төслүүд ялангуяа ТЭЦ 5, Тавантолгой гэдэг ч юм уу. Энэ үнэхээр хөрөнгө мөнгө нь шийдэгдээд явах гэж байсан ажлуудыг зогсоосны одоо өнөөдрийн гэдэг юм уу, ер нь зүгээр боломжит байдлаар ямар боломжоо бид хэд алдсан юм бэ? Үүнийг олон нийтэд хэлээдхээч. Хэчнээн айл орон сууцад орчих боломжтой байсан юм бэ? Хэчнээн бизнес эрхлэгч

бизнесээ тэлээд энэ үйлдвэрлэл тийм ээ, үүнийгээ өргөжүүлэх, шинэ үйлдвэр барих боломжтой байсан юм бэ? Хэчнээн энэ бараа материалын үнэ өртөг дээр энэ суурь ажиллах хүчнээс гадна энэ эрчим хүчний хамгийн бараа материалын үнэд шингэж байгаа зүйл байгаа. Хямдрах бололцоотой байсан юм бэ?

Монгол Улсыг ингэж удаа дараа хорлож байгаа хүмүүс дээр энэ танай салбарынхан ямар арга хэмжээ авах талаар санаачилга гаргаж байсан юм. Хаана хаанаа ойлголцлын юмнууд хийж байсан юм уу. Эсвэл энэ хууль хяналтын байгууллагад хандаж хэлж байсан юм уу. Энэ эдийн засгийн боломжит эдийн засагт оруулах байсан тэр боломжийн өртгийг хэлээдхээч. Би хоёрхон станц дээр л асууя. Тавантолгой, энэ 5 дугаар цахилгаан станц. Бид ийм зүйлүүдээ яг олон нийтэд ойлгуулах хэрэгтэй. Тэгэхгүй ингээд бүх зүйлийг гацаадаг, тэгээд ар хударгаар нь асуудлыг шийдэж байгаа биш нэг ийм жижигхэн юм оруулж ирж бид хэдийг үндсэндээ Монгол Улсыг шахаанд оруулж л явж байгаа шүү дээ.

Р.Сэддорж: Асуулт, хариулт байхгүй. Үг хэлнэ.

Цэнгүүн гишүүнийг нэмье. Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн: Өглөөний мэнд хүргэе. Тэгэхээр 3 дугаар цахилгаан станцтай холбоотой асуудал яригдаж байна. Тэгэхээр эрчим хүчний салбарт сая болж өрнөж байгаа энэ реформын хүрээнд шинээр хэрэгжүүлэх гэж байгаа төслүүдтэй танилцаж байгаа юм. Тэгэхээр яг энэ төслийн тухайд эдийн засгийн үр өгөөж ч байхгүй.

Дээрээс нь бид нар зайлшгүй ийм өндөр өртгөөр хэрэгжүүлэх боломжгүй төсөл байгаа гэдгийг нь салбарын хүмүүстэй уулзаад, мэргэжлийн инженерүүд нь ч гэсэн бүгдээрээ хэлж байгаа юм. Дээрээс нь эдийн засагч нартай ч гэсэн уулзалтуудыг яг энэ тусгайлж хэлсэн 3 дугаар цахилгаан станцын асуудал дээр хийсэн. Тэгэхээр миний зүгээс харж байгаа зүйл бол бид нар мэдсээр байж байж буруу үйлдэл хийх ёсгүй гэж бодож байна. Тэгэхээр Эдийн засгийн байнгын хороо дээр байгаа гишүүдээсээ эсрэг санал өгөхийг хүсье.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Гишүүд байрлалаа эзэлье, асуудлаа эзэлье.

Санал хураалт.

Монгол Улсын Улаанбаатар хотын дулааны 3 дугаар цахилгаан станцын өргөтгөл шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Санал нь ороогүй гишүүд байна уу. Батчимэг гишүүн. Батчимэг гишүүн горимын санал гаргая.

П.Батчимэг: Микрофоноо өгчих. Горимын санал. Юу, сая дэмжсэн юм. Тэгээд миний төхөөрөмж ажилласангүй. Хүчингүй болгоод дахиад санал хураалт явуулж өгнө үү?

Р.Сэддорж: Батчимэг гишүүний гаргасан горимын саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүй болгохыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Дахин санал хураалт.

65 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт хүчингүй болсон.

Санал хураалтыг дахин явуулъя. Соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Улаанбаатар хотын дулааны 3 дугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан танилцуулна.

Хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

11.27 цаг

Дараагийн хэлэлцэх асуудал 2.

Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн, СЗХ-ны орон тооны бус гишүүн, СЗХ-ны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, ҮСХ-ны зөвлөлийн гишүүнд тус тус нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Нэр дэвших хүсэлтээ ирүүлсэн хүмүүсийн танилцуулга, холбогдох материалуудыг та бүхэнд тараасан байгаа. Эдгээр танилцуулга, материалууд Эдийн засгийн байнгын хорооноос нээлттэй сонгон шалгаруулах зарын дагуу ирүүлсэн хүсэлтүүд байгаа. Хуульд заасны дагуу нэр дэвшүүлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтныг ирүүлэх нэр дэвшигчийг шууд нэр дэвшигчийн тухай сонголд оруулж, сонсголоороо хэлэлцэх учраас энэ сонгон шалгаруулалтад оруулаагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.6-д заасныг баримтлан нэр дэвшигч нэг бүрээр санал хураалт явуулж, олонхын саналаар нэр дэвшүүлэлт нэр дэвшигчийг дэмжинэ. Санал хураалтыг явуулахдаа санал хураалт явуулах ерөнхий дэгээ баримталж, нэр дэвшигч дэмжигдсэн тохиолдолд бусад нэр дэвших хүсэлт дэмжигдээгүйд тооцно. Тухайлбал нэр 1 дэвшигч сонгох квот дээр ирүүлсэн нэр дэвших бүх хүсэлтийг танилцуулж, санал хураах бөгөөд эхний нэр дэвшигч дэмжигдвэл бусад нэр дэвших хүсэлтийг дэмжээгүйд тооцож, тэдгээр хүсэлтээр санал хураалт явуулахгүй.

Эхний нэр дэвшигч дэмжигдээгүй тохиолдолд дараагийн нэр дэвших хүсэлтээр санал хураалт явуулна. Нэр дэвшихээр ирүүлсэн хүсэлтийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тохиолдолд нэр дэвшигч гэж тооцогдож, нэр дэвшигчийг дараагийн сонголд оруулна.

Эхлээд Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцье. Гишүүд санал хураалтад анхааралтай оролцож дэмжиж буй хүсэлт ирүүлэгчид саналаа өгнө үү.

Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшихээр ирүүлсэн хүсэлтээр санал хураалт явуулъя. Хүсэлт ирүүлсэн Н.Ууганбаатарыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Асуулт байхгүй. Хүнээ сонсгол дээр харна. Сонсгол дээр ярилцана, сонсгол дээр хүнтэйгээ ярилцана. Энэ бол зөвхөн хэнийг нэр дэвшүүлэх вэ гэдгээ л сонгож байгаа. Санал хураалт.

Санал хураалтыг цуцалъя. Жаргалан гишүүн горимын санал.

Б.Жаргалан: Энэ бүх материалуудтай бас яг танилцаж амжаагүй байна. Ялангуяа ийм хүний нэр дэвшилттэй холбоотой юм дээр шууд ингэж санал хураах чинь бас аягүй юутай л асуудал байна. Тэгэхээр түрүүний асуудал дээр бид нар жишээлбэл яамны мэдээллийг танилцаж амжаагүй гэсэн үндэслэлээр хойшлуулж байгаа тийм ээ. Гэтэл энд чинь бүр ингээд бүхэл бүтэн нэр дэвшилтүүд, нэр дэвшигч нарыг дэмжиж байгаа эсэх асуудал байгаад байна. Үгүй ээ, үгүй, энэ чинь сая дэгийг нь харсан чинь эхний хүнийг дэмжээд, тэгээд тэр орон тоогоор нь бөглөчих юм бол дараачийн хүмүүс дэмжигдээгүйд тооцно гэсэн дэгтэй юм байна шүү дээ. Тийм.

Тэгэхээр чинь ямар дарааллаар санал хураах вэ гэдгээс чинь хүртэл хамаарах гээд байна шүү дээ, тийм ээ. Ойлгосон. Би тэгж ойлгосон зөв үү, тийм ээ. Орон тоогоор нь бөглөөд, тэгээд үлдсэн хүмүүст нь болохоор дэмжигдээгүйд тооцогдоно гэсэн тийм дэгтэй юм байна шүү дээ. Тэгэхээр манайхан энэ дэгийг хэдүүлээ бас нэг ярилцъя тэгэх үү?

Р.Сэддорж: Олон нийтэд нээлттэй зарласан хүсэлтүүд дундаас л сонгож байгаа. Өнөөдөр бол. Олон нийтэд нээлттэй зарласан хүсэлтүүд дундаас л бид хэд сонгож, сонсголд оруулж байгаа байхгүй юу. Тэгээд сонсгол дээр танилцах, асуулт асуух, эцсийн санал хураалт чинь тэндээ явагдана. Яг 45 хүсэлт ирсэн. 20 орон тоон дээр. Тэгэхээрээ 20-оороо л оруулна гэсэн үг. Өнөөдөр 20-ийгоо л сонгоно гэсэн үг. Тийм, 20 дотроосоо даргад гэсэн хүсэлтээ бас тусдаа ирүүлсэн байх ёстой.

Ууганбаатар Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргад 1 хүн нэр дэвшсэн.

Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Бас адилхан саналтай байна. Өглөө хурал эхэлдэг. Хурлаас нэг 2 минутын өмнө ийм их материал гаргаад ирж байгаа юм. CV. Эд нар чинь Монголбанкийг удирдана, СЗХ-г удирдана ийм хүмүүс. Энэ чинь ингээд CV нь гараад ирэхээр ядаж хүснэгт гаргаад, Эдийн засгийн байнгын хорооноос нь энэ дээр нь ажиллацгаагаад, гишүүд ээ, ийм хүмүүс дэвшиж байна. Та хэд маань өөрсдөө хараад, тунгаагаарай. Боловсролоор нь, туршлагаар нь харьцуулсан хүснэгт гаргаад, нэг 2 слайд ч юм уу, 3 слайд ч юм уу, бэлдэж орж ирээд, тэгээд харьцуулж харж байгаад ядаж энэ хүмүүсийнхээ энэ юмыг хармаар байна шүү дээ. 2 минутын дотор тэгээд ийм 45 хүний юмыг унших юм уу. Боломжгүй шүү дээ. Тийм, хэн ч юм тэр нь одоо, хэний ч хүн юм. Тэгэхээр би энэ Эдийн засгийн байнгын хороондоо

санал хэлмээр байна. Энэ. Ийм их юм ирж байгаа юм бол үүнийгээ та нар боловсруулж байгаад, харьцуулсан зүйлийг нь үзүүлэх ёстой шүү дээ. Энэ ажлыг хэн хийх ёстой юм. Гишүүн болгон тус тусдаа хийх ёстой юм уу. Байнгын хороон дээр нь ирж байгаа мэдээллүүдийг бүгдийг нь нэгтгээд, анализ хийгээд, ойлгомжтой байдлаар тавиад, бид нарт биш, ард түмэнд ил болгох ёстой шүү дээ. Ийм хүмүүс нэр дэвшиж байна. Эдийн засгийн байнгын хороо үүнийг хэлэлцэх гэж байна гээд. Тийм ажил хийж болдоггүй юм уу?

Р.Сэддорж: Ажлын алба хариулья.

Д.Мягмарцэрэн: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье. Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд 3 байгууллагын нийт 5 юун дээр албан тушаал гэх юм уу даа, 5 зөвлөл дээр 20 нэр дэвшигчийг сонгох ёстой байгаа. Тэгээд үүнийг 14 хоногийн хугацаанд нөгөө олон нийтэд нээлттэй зарлаад, нийтдээ 45 хүний материал авсан. Бүр нийтдээ нэг 50 гаруй хүний материал ирсэн. Тэгээд түүнээс хуулийн шаардлага хангаагүйг нь хасаад, тэгээд хуулийн шаардлага хангаж байгаа хүмүүсийг нь ингээд оруулж ирсэн байж байгаа.

Байнгын хороо нөгөө намрын чуулганд шахагдаад уул нь 1 сарын хугацаатай ингээд зарлана гэж юу яаж байгаа. Тэгээд нөгөө намрын чуулганд шахагдаад 19-ний дотор материалыг жоохон шахуу авсан. Тэгээд нөгөө ер нь нэр дэвших хүсэлтээ ирүүлж байгаа хүмүүс дандаа л дэд ландад тулгаж 19-ний орой 17 цагийн үед л материалуудаа гаргаж өгсөн байхгүй юу. Тэгээд түүнээс хойш бид нар бүх материалуудыг нэг бүрчлэн тулгаад, энэ бүх анкетуудыг нэг бүрчлэн үзээд, тэгээд та бүхэнд ингээд ангилаад, тус тусад нь өгчихсөн байж байгаа. Нэр дэвшигчдийг тэгээд ерөнхийд нь биш, нэр дэвших хүсэлтүүдийг ерөнхийд нь ийм ийм хүмүүс хүсэлтээ ирүүлсэн гээд энэ ялгасан ийм хүснэгт ингээд гаргаад, та бүхэнд тараачихсан ингээд байж байгаа. Ер нь сонсголд ингээд. Ирээгүй байна уу? Үүнийгээ, тийм.

Тэгээд энэ нэр дэвших хүсэлтүүдээс Байнгын хорооны гишүүд сонсголд хэнийг оруулах вэ гэдгээ сонгоно. Сонсголд нөгөө нэр дэвшүүлж байгаа гишүүн нь одоо нэр дэвшигчээсээ асуулт асуугаад, материалтай нь бүрэн гүйцэд танилцаад тэгээд тухайн хүнийг томилох уу, үгүй юу гэдгээ 14 хоногийн хугацаанд, тийм. Ер нь бол энэ ирүүлсэн бүх хүсэлтүүдийгээ ангилж цэгцэлсээр байгаад өчигдөр, одоо шөнө 12 цагт бид нар дуусгаад тэгээд Байнгын хорооны хурлаас өмнө ямар ч байсан та бүхэнд ингээд энэ ангилсан хүснэгт, ерөнхий мэдээллүүдийг нь ингээд тараасан байж байгаа.

Р.Сэддорж: Сонсголоор шууд томилно гэсэн үг биз дээ. Сонсголоор бол шууд томилно гэсэн үг биш шүү дээ. Тийм, би хүртэл өглөө жагсаалтаа өглөө л харж байна шүү дээ, тийм. Тэгээд хуралдаан оруулаад л та бүхэнтэйгээ нээлттэй ярьж байгаа юм.

Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Мийгаагийн жагсаалтаар л энэ санал хураалт явчих гээд байна л даа. Тийм. Одоо Мийгаа энэ хяналтын зөвлөлийн дарга, гишүүд хэн болохыг үндсэндээ шийдэх гээд байгаа юм уу, ямар учиртай юм. Урьдчилж энэ чинь мэдээллээ ирүүлэх хэрэгтэй шүү дээ. Тэгээд энэ чинь эсвэл сонсгол явбал тэр 40 хүн дээрээ л сонсгол хэрэгтэй. Тэгээд тэндээсээ 20-оо сонгодог ч юм уу. Тэгэхгүй

бол үндсэндээ одоогийн санал хураалтаар шууд 50 хувиа хасах байна шүү дээ. Тэгээд таны гаргасан жагсаалтаар шүү дээ, хамгийн гол нь. Та яг дарга дээр нь шууд энэ Ууганбаатар гэдэг хүн шүү, санал болгоод явчхаж байна шүү дээ. Мийгаа. Ажлын алба санал болгоод байгаа юм уу.

Р.Сэддорж: Ажлын алба.

Д.Мягмарцэрэн: Энэ миний энэ сонголт гэхэд хэцүү л дээ. Би ирүүлсэн бүх материалыг ингээд бүх хүмүүсийн хүсэлтийг л та бүхэнд тараасан байж байгаа юм. Тэгээд. Тэгээд ийм учраас харин гишүүд нөгөө нэг яг алийг нь дэмжих вэ гэдгээ сонголтоо хийх хэрэгтэй. Бүх жагсаалтыг ингээд тэнд олшруулчихсан, уул нь тараасан. Өглөө бүгд бүх материалыг л тараасан байх ёстой. Нөгөө хэтэрхий их юу, учраас.

Р.Сэддорж: Найдалаа гишүүн горимын санал.

Б.Найдалаа: Яах вэ, энэ анкетуудыг халтихан харлаа. 2 минутын өмнө авлаа. Ер нь нөгөө салбарынх болоод би бүгдийг нь мэдэж л байна л даа. Хэн нь хэн бэ гэдгээ мэдэж байна. Гэхдээ одоо бид нар санал хураах гээд байна шүү дээ. Хүн сонгох гээд байна шүү дээ. Тэгээд дараа нь хариуцлага ярьдаг биз дээ? Дуудаад л сүртэй сүртэй юм ярьдаг биз дээ. Тэгэхийн тулд энэ сонгон шалгаруулалт, ажилд авахын тулд хүн ингэж авахгүй биз дээ.

Тэгээд ямар ч гэсэн энэ процесс буруу. Дэг ямар байх нь мэдэхгүй байна. Тэгэхдээ энэ ингэж, ингэж би лав энд оролцохгүй. Тэгээд хураах юм бол хураахаа хүрвэл нэг хүнээс биш үсгийн дарааллаар юм уу санамсаргүй байдлаа хурааж эхлэх нь зөв байлгүй дээ. Ер нь зүгээр энэ процессыг нь ч гэсэн би ойлгохгүй байна. Хэн нь 10 хүн дээр, 20 хүн дээр ингээд тус тусад нь хураагаад, оноо нь тэнцвэл яах юм, мэдэхгүй байна. Ер нь биш.

Р.Сэддорж: Ажлын алба тайлбарлана.

Д.Мягмарцэрэн: Энэ хүсэлтээ ирүүлсэн 45 хүнийг, бүгд дээр нь угаасаа санал хураалт явуулна. Энэ 45 хүнээс нь сонгож байгаа нь томилж байгаа гэсэн хэрэг биш. Үүнийг сонсголд оруулна, томилох тэр нэр дэвшигчтэйгээ танилцах, материалтай нь танилцах нь бол дараагийн асуудал. Энэ бол нийт 45 хүнийг сонсголд нөгөө дэгийн тухай хуулиараа зөвхөн нэр дэвшигчийг л сонсголд оруулна гэж байгаа учраас хэн хэнийг нэр дэвшүүлэх вэ гэдгээ Байнгын хороо одоо шийдэх юм. Тийм учраас энэ бол Байнгын хорооны гишүүдийн сонголтоор л шийдэгдэнэ ээ л гэсэн үг. Энд бол ... /минут дуусав/

Р.Сэддорж: Мөнхсоёл гишүүн горимын санал.

Б.Мөнхсоёл: Тийм, би нөгөө Найдалаа гишүүнтэй санал нэг байна. Ажилд авахад хүртэл эхлээд CV авна. CV аваад ярилцлага хийх хүртэл авсан намтруудаа нөгөө судалж байгаад 10 хүн ирлээ гэхэд 5-тай нь ярилцлага хийнэ. 5-ыг нь сонгодог шүү дээ. Сонгохын тулд намтрыг нь уншина. Дараа нь хүнтэй нь уулзаж ярилцлага хийж авдаг шүү дээ. Одоо бид нарт нөгөө өглөө ороод ирээд зөвхөн нэрүүдийг нь CV -тэй нь халти уншаад л ингээд л яахаар чинь шударга биш болох гээд байна. Дараа нь хэдэн хүн үлдчихээр түүн дотор нь маш сайн хүн хоцорчих вий гэдэг бас аюул эрсдэл байна шүү дээ. Тэгэхээр яалт ч үгүй бид нарт тэр бүх ирсэн пультэй

байгаа бүх хүмүүсийн намтар, ажил туршлагатай танилцах боломж өгөхгүй бол болохгүй. Баярлалаа.

Р.Сэддорж: Алдаржавхлан гишүүн горимын санал.

Ж.Алдаржавхлан: Энэ чинь ингээд хүн хасах гээд байгаа байхгүй юу. Бид нар. 1-ийг нь сонгоод хүн хасах гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ Их Хурлын гишүүдэд ядаж энэ хүний намтрыг унших эрх чөлөөг өгөөч гэж би хүсэж байгаа юм. Янз бүрийн тулгалт, юу байж магадгүй. Гэхдээ бид нарт ядаж, үүнийг уншиж танилцах тийм эрх чөлөөг өгөөч ээ гэж.

Тэгээд тийм бололцоог хангаж өгөхгүй бол хүн хасах гээд байна шүү дээ. Танихгүй хүн нь хасах гээд байгаа байхгүй юу. Ядаж уншиж үзээд тэр манай Лукагийн хэлдэг зөв л дөө. Тийм харахад ойлгомжтой таблиц хийгээд өгчихвөл бид нар уншаад л ийм ийм хүн юм байна гээд л бодож болно шүү дээ.

Р.Сэддорж: Хэлэлцэх асуудлын хамгийн сүүлд оруулъя.

Өнөөдрийн хэлэлцэх асуудлын. Тэр хооронд гишүүд маань бас уншиж танилцаад, тэгээд хүнтэйгээ танилцаад, ерөнхийдөө ингээд зарим албан тушаал дээр ганц л хүн ирсэн юм байна шүү дээ, ганц л хүн ирсэн юм байна. Ингээд хэлэлцэх асуудлын хамгийн сүүлд оруулъя. Үүнийг хойшлуулах ямар ч боломжгүй байгаа. Гишүүдийг мэдээллээр хангая. Наад хүснэгтээр хангая. Ажлын алба.

11.44 цаг

Хэлэлцэх асуудал. Дараагийн хэлэлцэх асуудал.

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 83 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн танилцуулгыг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийг танилцуулгаа танилцуулахыг урьж байна. Гишүүний микрофоныг нээе.

Х.Ганхуяг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн ажлын хэсэг байгуулах тухай 83 дугаар захирамжаар Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, холбогдох санал, дүгнэлт боловсруулж, хуулийн төсөл боловсруулан Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг, ажлын хэсгийн гишүүдээр Аубакир, Бат-Амгалан, Батбаатар, Заяабал, Отгонбаяр, Очирбат, Сэддорж, Хосбаяр нарын 9 гишүүн ажиллаж байна.

Ажлын хэсэг зөвшөөрлийн чиглэл тус бүрийн иргэн, хуулийн этгээдтэй 3 удаагийн хэлэлцүүлэг хийж, саналыг авсан бөгөөд мөн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд буюу Засгийн газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, төрийн зарим чиг үүргийг хуульд эсвэл гэрээнд заасны дагуу шилжүүлэн авсан этгээдтэй тус тус 14 удаагийн уулзалт, хурал хийж, гадаад улсын зөвшөөрлийн харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн зохицуулалт, туршлагыг судлан, Зөвшөөрлийн тухай хуулийн

хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг мэргэжлийн судлаач, зөвлөхүүдээс бүрдсэн хөндлөнгийн багаар гүйцэтгүүллээ.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн Зөвшөөрлийн тухай хуулийг баталсан бөгөөд хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд багагүй хугацаа өнгөрч байна. Уг хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны төрөл, жагсаалт болон эдгээрт холбогдох суурь харилцааг зохицуулж байгаа бөгөөд хуулиар хориглоогүй буюу хуульд зааснаас бусад үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээд чөлөөтэй эрхлэх боломжийг бүрдүүлсэн юм.

Хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, холбогдох байгууллагуудын мэдээлэлд үндэслэн дараах асуудлыг Байнгын хороонд танилцуулж байна. Зөвшөөрлийг шинээр бий болгоход тухайн үйл ажиллагааг төрөөс зохицуулах шаардлагатай эсэх, зөвшөөрөл нь зохицуулалтын зохистой арга хэрэгсэл мөн эсэх, зөвшөөрөл, нийгэм эдийн засгийн хувьд үр ашигтай байх эсэх, судалгаа, хяналтын шинжилгээ, эрсдэлийн үнэлгээг хийгээгүй, хуульд заасан үндэслэл шаардлагыг хангахгүйгээр Зөвшөөрлийн тухай хуульд тусгай энгийн зөвшөөрөл нэмсэн, хассан, өөрчилсөн, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, нийтийн ашиг сонирхол, үр ашигтай өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх үүднээс зарим төрлийн үйл ажиллагаанд тодорхой хязгаарлалтыг хийгээгүйгээс бусад давуу байдал ашиг сонирхлын зөрчил үүссэн, хуулиар захиргааны хэм хэмжээний акт гаргахыг хориглосонтой холбоотойгоор бүртгэлгүй захиргааны хэм хэмжээний актаар зөвшөөрөл олгох, хуулиар тусгайлан олгосон эрх хэмжээний харилцааг журмаар өргөжүүлсэн, зөвшөөрөлгүй эрхлэх үйл ажиллагааны салбарын хууль журмаар бүртгэл, эрх олголт, дүгнэлт гэх зэрэг баримт бичгүүдээр зөвшөөрөлтэй олгож эрхэлсэн байдаг.

Дээр дурдсан асуудал нь хууль хэрэгжихгүй байх гол нөхцөлийг бүрдүүлж байх бөгөөд цаашлаад хэм хэмжээнүүдийн уялдаа алдагдаж, сөрөг үр дагавар гарах өндөр эрс нийцэлтэй байна. Зөвшөөрлийн тухай хуулийн салбарын 180 гаруй хуулийн зохицуулалтыг хангах суурь хууль бөгөөд шийдвэрлэх харилцаанд өргөн хүрээг хамардаг тул хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл, зөрчил практикт гарч буй асуудлын шалтгаан нөхцөлийг эрт илрүүлж, эдгээртэй уялдуулан хуулийг боловсронгуй болгоход анхаарах шаардлагатай байна.

Иймд ажлын хэсгээс Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмын дагуу Эдийн засгийн байнгын хорооны тогтоолоор хуулийн биелэлтийг эрчимжүүлэх, холбогдох арга хэмжээ авах тухай чиглэлийг Засгийн газарт хүргүүлэх саналыг гарган, тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төсөлд хуулийн хэрэгжилт, биелэлтийг хангах үйл ажиллагааг эрчимжүүлэх, зөвшөөрөл тус бүрд эрсдэлийн үнэлгээ хийх, аливаа үйл ажиллагааг дур мэдэн зөвшөөрүүлж байсан, хуулиас давсан журмаар зөвшөөрөл олгосон тохиолдолд хариуцлагын асуудлыг чангатгах, мөн Зөвшөөрлийн хууль тогтоомжтой салбарын хуулийг нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зэрэг асуудлыг тусгасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон Байнгын хорооны

тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхэн хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн танилцуулга болон Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Лувсанжамц гишүүнээр тасалж байна. Ж.Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Энэ Зөвшөөрлийн тухай хууль дээр Ганхуяг гишүүн их сайн ажилласан. Тэгээд үүнийгээ бас хэрэгжилтэд нь бас анхаараад явж байгаа нь сайн байна. Тэгээд энд тогтоолын тэр 4 дээр байгаа, би түрүүн бүтнээр нь уншиж өгсөн. Нөгөө хэлэлцэх асуудал дээр. Хойшлуулаач ээ гэсэн саналтай байсан юм уг нь. Үүнийг тэгээд энэ маань 1 дүгээрт, өчигдөр энэ гишүүд хэлээд байна л даа. Өглөө бүр цахимаар ирсэн л дээ. Энэ өчигдөр ч ирээгүй.

2 дугаарт, энэ хар аа, ийм байгаа юм аа, Ганхуяг гишүүн ээ, Байнгын хорооны дарга аа. Энэ хэрвээ үүнийгээ нарийвчлан зохицуулах гэж байгаа биз дээ, таслал тавиад. Тэгээд дараа нь дуудлага худалдаа сонгон шалгаруулалтаар төвлөрч буй орлоготой холбогдох эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгох. Түүнийг нь болох байх. Тэр нарийвчлан зохицуулах гэхээр юу сонсогдож байгаа вэ гэхээр шууд дарга лиценз өгдөг болно шүү. Нэг сайд, нэг дарга лиценз өгдөг болно. Наадах чинь намайг сайд байхад их олон хүмүүс наадхыг чинь хүсэж байсан юм шүү. Тэгээд л, тэгээд 1 эрх мэдэлтэн лиценз өгдөг ийм хэлбэр лүү явна шүү. Үүнийг их олон хүмүүс хүсэж байгаа юм. Өнөөдрийн тэр сонгон шалгаруулалтын тогтолцоо чинь тийм нэг хүний хүсэл сонирхлоор, тэгээд олгох боломж байдаггүй юм. Ер нь бас нэлээн тийм зүгээр төгс юм гэж байхгүй л дээ. Өнөөдөртөө бол ер нь Монголд боломжийн зохицуулалт, тэр сонгон шалгаруулалт гээд явж байгаа юм. Тэгээд хэн дуртай хүн нь лиценз аваад, түүнийг дамлан худалдаад, мөнгөний хэрэгсэл болгоод явдаг зүйлийг хаасан өнөөдрийн тогтолцоогоо эвдчих вий гэж би санаа зовж байгаа юм.

Тэгээд энэ чинь ийм байна л даа. Тэр төрийн нийтийн өмч, байгалийн баялгийн ашигтай холбоотой дуудлага худалдаа эсвэл сонгон шалгаруулалтын журмыг нарийвчлан зохицуулах гэдэг чинь өөрчлөлт оруулна л гэсэн үг. Үүнийгээ хөндөнө өө л гэсэн үг. Их олон юм надад сонсогдож байгаа юм, зүгээр. Тэгэхээр ийм байж болохгүй. Хэн нэгэн албан тушаалтан, одоо өмнө бүр 16 оноосоо өмнөх 12 оноос өмнөх юм руугаа буцах нь байна шүү дээ. Тэгээд 1 хамгийн хүчтэй нь билүү, нэг бөхчүүд очерлоод байдаг, эсхүл Сайд, дарга нар шууд лиценз олгочихдог ийм байдал руу болохгүй. Үүнийг хасах ёстой. Бусад дээр нь санал алга. Энэ тэгээд, мэдээж хуулийн хэрэгжилтээ хэрэгжүүлээд явах нь зөв. Энэ аж ахуйн ялангуяа бизнес эрхлэгч нарт энэ Зөвшөөрлийн тухай хуулийг хэрэгжихгүй байна гээд байгаа л даа. Энэ бусдыг нь дэмжиж байна. Дууслаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн ахлагч Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Ганбаатар гишүүний санаа зовниж байгаа асуудал бол зөв өө. Гэхдээ энэ асуудал нь ийм байгаа юм. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.1 дэх хэсэг, 1.8, 1.15. Энэ ямар зөвшөөрлүүдийг хэлээд байна аа гэхээр бид нар урьд өмнө нь гарын үсгээр өгдөг байсан энэ зөвшөөрлүүдийг дуудлага худалдаа юм уу, сонгон шалгаруулалтаар явуул гэдэг ийм байдлаар Зөвшөөрлийн хууль батлагдсан. Энэ батлах батлахдаа Зөвшөөрлийн хуулийнхаа 5.6.2 дээр энэ зүйлийн 1-д заасан журмаар зөвшөөрлийг олгох харилцааг тухайлсан хуулиар нарийвчлан зохицуулна гээд оруулсан байгаа юм. Энэ зөвшөөрлүүд нь ямар зөвшөөрлүүд байна гэхээр

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.1 дэх хэсэгт заасан байгаль орчны чиглэлийн 6 зөвшөөрөл. Энэ дотор генетик нөөц, генетикийн нөөцтэй холбоотой, уламжлалт мэдлэгийг ашиглах, ховор амь, амьтан цуглуулга хийх, тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих, үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих, элбэг ургамлыг үйлдвэрийн зориулалтаар ашиглах, ойн дагалт баялгийн нөөцийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах гэх мэтчилэн энэ тусгай зөвшөөрлүүдийг дуудлага худалдааны зарчмаар явуулдаг болсон байгаа.

Хуучин энэ самар бол дандаа гарын үсгээр явдаг байсан юм. Гэхдээ яагаад үүнийг нарийвчлан зохицуул гээд байгаа вэ гэхээр салбарынхаа хууль дээр тухайлбал самрын дуудлага худалдааг, эсвэл ойн дагалдах дуудлага худалдааг ойн анги зохион байгуулна гээд орчихсон байгаа байхгүй юу. Ойн анги яаж дуудлага худалдаа зохион байгуулах юм. Тэгэхээр энэ хуулиа нарийвчлан зохион байгуул, зохицуул гэдэг байдлаар чиглэл өгч байгаа гэсэн үг.

Мөн 6 дахь зүйлийн хэсэгт заасан санхүү, эдийн засаг, гааль, хөрөнгө оруулалтын чиглэлийн зөвшөөрөл буюу татваргүй барааны дэлгүүр ажиллуулахыг сонгон шалгаруулалтаар хий, эсвэл дуудлага худалдаагаар явуул гэж байгаа. Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлийн 7 зөвшөөрлийг буюу арилжааны радио, телевизийн үйлчилгээ эрхлэх, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх, өргөн нэвтрүүлгийн радио телевизийн үйлчилгээ эрхлэх, радио давтамж ашиглах гэх мэтчилэн ийм зөвшөөрлүүдийг сонгон шалгаруулалтаар юм уу, дуудлага уулзалтаар явуул гэдэг. Энэ бол Зөвшөөрлийн хууль батлагдаж байхад оруулсан заалтууд байгаа юм.

Тэгэхээр энэ зохицуулалтууд маань учир дутагдалтай байна. Ийм учраас эд нарыгаа сайн хараач ээ. Тэгээд зохицуулалтуудаа хийгээд өргөн бариач ээ гэдэг байдлаар л Байнгын хорооноос тогтоол гарч байгаа гэсэн үг.

Р.Сэддорж: Ганбаатар гишүүн тодруулъя.

Ж.Ганбаатар: Би зүгээр, тэр байгалийн баялаг гэдгийг бол шууд нөгөө ашигт малтмалын юу гэж шууд уншигдаж байна л даа. Түүнээс биш бусад нь хамаа алга. Таны хэлж байгаа тэр, тэр зүйлүүд зөв. Тэр самар ч гэдэг юм уу, тэр өргөн телевиз, тэрэнд зөв байх. Энэ байгалийн баялаг гэдгийн чинь цаана шууд л ашигт малтмал гэж уншигдаж байна шүү дээ.

Тийм учраас үүнийгээ нарийвчлаад зохицуул аа. Өнөөдөр яг таны хүсэж байгаагаар салбарынхаа хуульд суучихсан, сонгон шалгаруулалт нь. Одоо ашигт малтмалын лиценз олголт чинь сонгон шалгаруулалтаар явж байгаа. Дуудлага худалдааны хэлбэр бараг 70 хувьд нь үйлчилж байгаа. Та сайн мэдэж байгаа байх. Тэгээд яг таны хүсэж байгаа чинь хууль дээр суучихсан байгаа байхгүй юу. Одоо надад юу сонсогдож байна гэхээр түүнийг чинь өөрчлөх гээд байна. Түүнийг чинь хэн нэгэн хүн мэддэг, шууд гарын үсгээрээ лиценз олгодог болгочих гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ чинь өөрөө тийм үүд хаалга нээж өгөх вий, наадах чинь ийм байх болохгүй шүү гэдгийг би сануулж хэлээд байгаа юм.

Р.Сэддорж: Ажлын хэсэг Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Үүнийг та харвал, төрийн нийтийн өмч, байгалийн баялгийн ашиглалттай холбоотой дуудлага, эсвэл сонгон шалгаруулалтын журмыг

нарийвчлан зохицуулах гэж байгаа юм. Ашигт малтмал угаасаа хуулиараа зохицуулгатай явж байгаа. Одоо түүн дээр тэр дуудлага худалдаатай юм уу, сонгон шалгаруулалттай холбоотой асуудал орчихсон байгаа. Гэхдээ бусад 22 төрлийн төрийн нийтийн өмч болон байгалийн баялгийн хуулиудыг энэ дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтын журмуудаа хуульдаа тусгаад, өргөн барь гэдэг асуудлыг хөндөж байгаа гэсэн үг. Тухайлбал зөвхөн өнгөрсөн жил би танд нэг жишээ хэлэхэд амьтныг тусгай зориулалтаар агнах, барих, амьтны дуудлага худалдаа явуулахдаа нийтдээ улсын төсөвт 3 тэрбум төгрөгийн орлого орсон байгаа юм. Гэхдээ энэ улсын төсвөө татаад, эргээгээд нөгөө ан амьтнаа хамгаалах байдаг юм уу, нөгөө үржүүлэх байдаг юм уу, энэ тал руугаа ерөөсөө хөрөнгө зарцуулагдахгүй байгаа. Тэгэхээр энэ эргээгээд бид нар тэр орон нутагт нь эргээгээд мөнгийг нь үлдээдэг. Эсвэл тэр ой агнах, хамгаалах ангид нь мөнгө төвлөрүүлдэг байх энэ зохицуулалтуудаа хамтдаа өргөн бариач ээ гэдэг асуудал байж байгаа.

Байгалийн баялаг гэдэг маань зөвхөн ашигт малтмал биш ашигт малтмал угаасаа хууль ... /минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж байна. 1 минут.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Тэгэхээр үүнийг хэн Ганхуяг гишүүн ээ, та бид 2 мэтгэлцэж байгаа юм. Их соёлтой мэтгэлцэж байгаад баярлалаа. Тэгээд энэ хэн юуг ашигт малтмал гэдгийг нэг тодруулахаа оруулахгүй бол энэ чинь том үүд хаалга нээнэ. Хэн ээ, хэн Байнгын хорооны дарга аа, уул нь бол энэ том хууль зөрчих асуудал үүснэ. Тэгээд би зүгээр салбарын сайд байсан хүний хувьд би хэлээд байна шүү дээ. Наана чинь олон зүйл сонсогдож байгаа. Эрх мэдэл бүхий хүмүүс чинь бараг өөрийнхөө гарын үсгээр лиценз өгье өө гээд гүйгээд явж байна шүү дээ. Ээнэ чинь ийм үүд хаалга нээчих магадлалтай шүү.

Тийм учраас миний санал бол тэгвэл ашигт малтмалд үйлчлэхгүй ч гэдэг юм уу, мэдэхгүй тийм үүд хаалга нээж өгөхгүй байх тэр зохицуулалтыг хийгээрэй. Сануулж хэллээ шүү. Үүнийг протоколд би бүр суулгаад, бүр сануулж хэллээ. Энэ бол томоохон юм гарах үүд хаалга болно шүү. Нарийвчлан зохицуулж байна гээд л ... /минут дуусав/

Р.Сэддорж: Ажлын хэсэг Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Зөвшөөрлийн хуулийн үндсэн концепц бол зөвшөөрөлтэй холбоотой ямар нэгэн журам гаргахыг хориглочихсон байгаа юм. Энэ журмаа зохицуул гэдэг маань одоо энэ хуулиар эрх аваагүй, хуулиар зохицуулах тухай юман дээр хуулиар зохицуул гэдэг л агуулгаар орж ирж байгаа юм. Хуулиар зохицуул гэсэн үг. Эсвэл тухайн салбарынхаа хууль дээрээ, тийм, тэгэхээр тэр бол оролдохгүй гэсэн үг. Бусад тэр ан агнуур байдаг юм уу, тэр хуулиар зохицуулахгүй юман дээр та нар хуульдаа нарийвчлан зохицуулалтаа хий гэдэг асуудал.

Журмыг ямар тохиолдолд гаргаж болж байгаа вэ гэхээр зөвхөн шалгуур шаардлагатай холбоотой эсэх талаар л журам гаргаж болно. Бусдаар зөвшөөрөл олгох харилцаатай холбоотой ямар нэгэн журам гарахыг угаасаа Зөвшөөрлийн хуулиар хориотой юм, хориотой юм. Тэгээд үүнийг бас зориудаар протоколд авхуулчихъя.

Р.Сэддорж: Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Богино хугацаанд. Энэ Зөвшөөрлийн тухай хууль бас их чухал хууль байгаад байгаа. Тэгээд богино хугацаанд маш идэвхтэй ажиллаад олон удаагийн стэйк холдерууд буюу хамрах хүмүүсийг цуглуулсан ийм ажлын хэсэг болоод үр дүн гарсан байна гэж ойлгож байна. Таны хэлж байгаа энэ нөгөө хуулийн биелэлтийг эрчимжүүлэх, холбогдох арга хэмжээ авах тухай чиглэлийн материал надад ирээгүй байгаад байна. Энэ Эдийн засгийн байнгын хорооны групп чат дээр ч гэсэн байхгүй байгаад байна. Энэтэй нарийн танилцаад бас саналуудаа бичгээр өгье гэж бодож байгаа. Тэгээд одоогийн байдлаар ерөнхийд нь нөгөө хот байгуулалтын салбараасаа бас тантай нэг бас ганц 2 бас санал бодол солилцье гэж бодоод байгаа юм.

Ер нь хувь хүн, ААН бизнес хийгээд, хөдөлмөр эрхлээд, амьдралаа залгуулаад авч явъя гэхдээ төрөөс зөвшөөрөл авна гэдэг нь угаасаа хоцрогдсон зүйл. Төр нь яахаараа ч тэр хүн ажил хийх гээд байгааг нь зөвшөөрөх ч ёстой байдаг юм. Яах вэ, тодорхой хэмжээний болж, болохгүй зүйлүүдийг зохицуулах гээд байгаа байх л даа. Гэхдээ манай Улаанбаатар хотод жишээ нь гуанз ажиллуулахын тулд зөвшөөрөл авах хэрэгтэй болчихдог. Зун ингээд шорлог, мах шараад зогсож байхад, цагдаа нь очоод энд болохгүй гээд хөөгөөд явуулчихдаг, ийм зохицуулалтыг уг нь бүгдээрээ хот байгуулалтын бүсчлэл буюу хот байгуулалтын тухай хууль, хот төлөвлөлтийн ч юм уу, тийм ээ, тийм зарчим дээрээ тусгаж өгөөд, тухайн бүсэд хүлээн зөвшөөрөгдсөн, зориулсан тэр бүсчлэл нь тийм зориулалтаар байх юм бол бизнес эрхлэх чөлөө зөвшөөрөл нь шууд олгогддог байдлаар явдаг тийм ээ. Эсрэгээрээ яах вэ, стандартыг нь хангаж байгаа эсэх нь араас нь эрүүл мэндийн байгууллага нь очоод шалгадаг ч байдаг юм уу. Тийм байдлаар хэрэгждэг нэг тийм олон улсын стандарт руу шилжээд, энэ иргэд, ААН-үүд бизнес эрхлэх эрх чөлөөг нь нээж өгөх боломж бололцоо чухал гэж бодоод байгаа юм.

Тэгээд миний хэлэх гэж байгаа гол санаа бол энэ нэгэнт ийм чиглэл гаргах гэж байгаа бол Хот байгуулалтын тухай хууль дээр бүсчлэл гэж зааж өгч байгаа. Тэр бүсчлэлд нь нийцсэн зөвшөөрөл нь шууд олгогддог байдлаар, төлөвлөгөө байхад зөвшөөрөл шууд олгогддог хэлбэрээр, даргын гарын үсэг биш ямар нэгэн ямбатай нэг төрийн албан хаагчийн зөвшөөрлөөр биш, хот төлөвлөлт дээр нь шууд зөвшөөрөл нь олгогддог ийм тогтолцоо руу шилжих ёстой гэж бодоод байгаа. Тэгээд таны энэ гаргаж байгаа чиглэлтэй танилцаад бас нарийн саналуудаа бас тусгая гэж бодож байна. Энэ дээр та ямар бодолтой байгаа вэ?

Р.Сэддорж: Ажлын хэсэг Ганхуяг гишүүний микрофоныг.

Х.Ганхуяг: Ер нь энэ зөвшөөрлийн хууль гарах болсон шалтгаан бол яг таны санаа зовниж байгаа асуудалтай холбоотойгоор анх гарсан юм. Нэг ёсондоо бид нар төрийн нийтийн өмчийг ашиглах, байгалийн баялгийг ашиглах, ямар нэгэн эрсдэлтэй үйл ажиллагаа дээр л зөвшөөрөл байх байдлаар бид нар жагсаалт хийж, нийтдээ 1600 зөвшөөрлийг 362 болгосон юм. Гэхдээ бид нар сая ингээд судалгаа хийгээд явсан. Үндсэндээ бүртгэл, дүгнэлт гэсэн нэрээр асар олон шинээр зөвшөөрлийг бий болгочихсон байгаад байгаа.

Тэгээд тэд нарыг бүгдийг нь шүүрдэх ажиллагаа хийгдэнэ гэсэн үг. Үндсэндээ бид нар эрсдэлийн үнэлгээ, үр дагаврын, одоо Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн, үр дагаврын үнэлгээний тайлан гээд 200 гаруй хуудастай тайлан бид нар дээр бэлэн байна. Сая энэ өнгөрсөн 2 сарын хугацаанд манай ажлын хэсгийн хийсэн ажил гэсэн үг. Үүнийг Байнгын хорооны гишүүдэд тараалгаагүй. Та хүсвэл

бид нараас авч болно. Гэхдээ бид нар ингэж Засгийн газар луу чиглэл өгөөд, Засгийн газраар зөвшөөрөл ба мэдэгдлийн хууль гэсэн байдлаар Зөвшөөрлийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр өргөн барина гэсэн үг. Одоо бүртгэлүүдийг бүгдийг нь цэгцлээд, бүртгэлүүдээ мэдэгдэл болгох байдлаар бид нар бас мэдэгдлийн жагсаалт гаргана гэсэн үг. Тэгээд үндсэндээ энэ 1, 2 дугаар сарын үед Засгийн газраас өргөн мэдүүлнэ. Тэгээд дараа жилийн хаврын чуулганаар батлуулах юм байгаа юм. Тэгээд яг тэр барилгатай холбоотой асуудал дээр та өөрөө бас саналаа бас тухайн үед нь бас өгч болно. Тийм.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн танилцуулга болон Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа.

Санал хэлэх гишүүд нэрсээ өгье. Саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүд алга байна.

Ингээд Байнгын хорооны санал хураалт явагдах гэж байгаа тул гишүүд суудлаа эзэлье.

Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, холбогдох арга хэмжээ авах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Тогтоолыг уншъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол. Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, холбогдох арга хэмжээ авах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

Нэг. Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, тулгарч буй асуудлыг шийдвэрлэх хүрээнд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай.

1. Зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай, энгийн зөвшөөрөл тус бүрд эрсдэлийн үнэлгээ хийх, үнэлгээнд үндэслэн эрсдэлийн түвшнийг тодорхойлох,

2. Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд үндэслэн зөвшөөрөлгүй эрх эрхлэх үйл ажиллагааг бүртгэл, эрх олголт, дүгнэлт зэрэг баримт бичгээр зөвшөөрүүлсэн, эс үгүй бол нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актад бүртгэлгүй захиргааны актаар зөвшөөрөл олгож буй асуудлын хуулийн хариуцлагыг чангатгах,

3. Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, нийтийн ашиг сонирхол, үр ашигтай өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх үүднээс зарим төрлийн үйл ажиллагаанд тодорхой хязгаарлалт хийх, эрх зүйн орчныг тодорхой болгох,

4. Төрийн нийтийн өмч, байгалийн баялгийг ашиглахтай холбоотой дуудлага худалдаа, эсхүл сонгон шалгаруулалтын журмыг нарийвчлан зохицуулах, дуудлага худалдаа сонгон шалгаруулалтаас төвлөрч буй орлоготой холбогдох эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгох,

5. Зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг бүрэн хамруулах, холбох, нэвтрүүлэлт хийх, зөвшөөрлийн нэгдсэн сангийн цахим системийг үүсгэх, хөгжүүлэх, хяналт тавих, цахим систем, мэдээллийн чанар, уялдаа холбоог сайжруулах, мэдээллийг нийтэд нээлттэй ил тод байршуулах, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах ажлыг эрчимжүүлэх,

6. Эрсдэлийн үнэлгээ түвшинтэй холбогдуулан шаардлагатай тохиолдолд хуулийн нэр томьёо, эрх зүйн зохицуулалтыг оновчтой тодорхойлох, Зөвшөөрлийн тухай хууль, салбарын хууль тогтоомжийг нийцүүлэх, уялдааг хангах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, холбогдох хуулийн төслийг боловсруулах,

Хоёр. Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд 2025 оны хаврын чуулганы хугацаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосугай.

Гурав. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай. Байнгын хорооны дарга.

Тогтоолтой холбогдуулан асуулт, санал байхгүй.

Ингээд энэхүү тогтоол, хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, холбогдох арга хэмжээ авах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

65 хувиар санал дэмжигдлээ.

Батсүмбэрэл гишүүнийг төхөөрөмж ажиллаагүй тул дэмжсэнд санал тооцъё. Санал дэмжигдлээ.

Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, холбогдох арга хэмжээ авах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

12.07 цаг

Ингээд хэлэлцэх асуудлын дараалал ёсоор нэр дэвшигчийн Сонсголын тов тогтоох тухай, сонсголын даргалагчийг сонгох тухай тогтоолыг хэлэлцье.

Хүмүүсийн тухай асуудлыг үүний дараа хэлэлцэх учраас эхлээд хэдүүлээ энэ сонсголынхоо тов, даргалагчийг сонгоё.

Ингээд Байнгын хорооны тогтоол, нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох тухай, сонсгол даргалагчийг сонгох тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, 130 дугаар зүйлийн 130.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, СЗХ-ны орон тооны бус гишүүн, СЗХ-ны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, ҮСХ-ны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 01 дүгээр сарын, энэ өдрийг 08-ны өдрөөр зохион байгуулахаар тогтоосугай.

Нэр дэвшигчийн сонсголыг даргалагчаар миний бие ажиллах ийм саналтай байна.

3. Нэр дэвшигчдээс асуух асуулт, саналыг 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийг хүртэл хүлээж авахаар тогтоосугай.

4. Нэр дэвшигчийн сонсголын зарыг нийтэд мэдээлэх, сонсголын бэлтгэл хангах ажлыг холбогдох хууль дүрэмд заасны дагуу зохион байгуулахыг Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай гэсэн. Энэхүү тогтоолын төсөлтэй асуух асуулт байна уу? Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Зүгээр ийм санал байгаа. Гэхдээ та хэд олонхоороо шийднэ биз дээ. 07-ны өдөр хүртэл авчхаад 08-нд шууд хэлэлцээд эхлэхээр яадаг юм бол? Тийм ээ, 07-ны орой хүртэл авангуутаа 08-ны өглөө хэлэлцээд эхлэхээр бид нарт бас цаг хугацааны хувьд уншиж танилцах, судлах материалууд маань яадаг юм бол. Ядаж нэг 2, 3 хоног хойшлуулах бололцоо байхгүй юу? Тийм боломж байна уу? 07-ны орой хүртэл аваад, 08-ны өглөө хэлэлцэнэ гэхээр чинь. Түүнийг хариулж өгөөч, тэгэх үү? Үгүй ээ үгүй. Сонсголоо чинь 07-ны хүртэл нээлттэй гэж байна шүү дээ. Материал авна гэж байна шүү дээ. Сая тэгж байна шүү дээ. Би буруу ойлгоогүй.

Р.Сэддорж: Олон нийтээс бас асуулт гарч ирж байх магадлалтай. Түүнийг л авч байгаа юм. Тийм, ер нь 14-нд болговол яасан юм, тийм. 07-нд материалуудаа олон нийтээс гарсан саналуудыг авч дуусаад, 14-нд. 14-ний хурлаар хэлэлцвэл яасан юм бэ гэсэн санал оруулж байна. 14-нд, сонсголоо. Тийм. Тийм 14-нд хэдүүлээ яг нэлээн нөгөө хугацаа, энэ чинь нөгөө чуулганы хаалт болохоос өмнөхөн нь хэлэлцэж байна гэсэн үг. Тийм ээ, тэгээд 14-нд эцсийн байдлаар ингээд шалгаруулалт дуусна. 16-нд, 7-нд л гэж төлөвлөж байгаа юм. Сунгаж магадгүй.

Ингээд тогтоолыг баталъя гэсэн саналтай гишүүд дэмжье, батлахыг дэмжиж байя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

75 хувийн саналаар тогтоолын төсөл санал батлагдлаа.

12.12 цаг

Одоо нэр дэвшигчдийн нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцэж, санал хураалтууд явагдана.

Ганхуяг гишүүн горимын санал.

Х.Ганхуяг: Та угаасаа ингээд нөгөө сонсголоо зохион байгуулна. Тэгэхээр бид нар өнөөдөр ингээд 45 анкет ирсэн юм байна. Тэгээд яах вэ, өнөөдөр нөгөө анхан шатны бүр эхний филтер дэх ажил хийгдэх гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр магадгүй бид нар өнөөдөр 20 биш, тэр 45-аасаа 30 анкет ч юм уу сонгоод, тэгээд

сонсголынхоо явцад тэр 20-ийгоо авч үлдэх ийм байдал руу явбал ямар вэ? Ийм байж болох уу, үгүй юу, Мийгаа дарга аа? Тэгчихвэл дараа нь тэр чинь энэ дотор чинь бас болох, болохгүйг нь мэдэхгүй баахан хүмүүс сонгочихдог. Тэгээд дахиад л буцаад л нөгөө өмнөх анкет руугаа очиж байхаар, магадгүй нэг 30 хүний анкет ч юм уу сонгоод, тэгээд тэрийгээ сонсголынхоо явцад явуулаад нэг 20 хүнээ авч үлдэхээр байвал яадаг юм.

Үгүй ээ, харин тэгээд л нэр дэвшигчийг л оруулах гэж байна шүү дээ, бид нар, тийм.

Р.Сэддорж: Юу яая, микрофон дээр хэлэх үү? Ажлын алба тайлбарлана.

Д.Мягмарцэрэн: Дэгийн тухай хуулиар нэр дэвшигчийг сонсголд оруулна гэж байгаа. Одоо энэ бол зөвхөн хүсэлт байхгүй юу. Нэр дэвшүүлэх хүсэлт. Тэгэхээр энэ хүсэлтээс хэнийг нь нэр дэвшүүлэх вэ гэдгээ Байнгын хороо шийдэх гээд байгаа л гэсэн үг. Тэгэх боломж байхгүй.

Р.Сэддорж: Их Хурлын Тамгын газраас. Их Хурлын Тамгын газрын микрофоныг нээе.

Гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээ мониторинг хариуцсан дэд дарга Амарбат Байна. Энэ нэр дэвшүүлэх ажиллагаа маань 2 хуулиар зохицуулагдаж байгаа.

1 дүгээрт, Улсын Их Хурлын тухай хууль. Улсын Их Хурлын тухай хуульд Байнгын хороо сонсгол руу тухайн мандаттай ижил тооны хүмүүсийг нэр дэвшүүлж оруулах ийм зохицуулалт байгаа. Тэгээд тэр сонсгол дээрээс хэрвээ ямар нэгэн байдлаар хүн хасагдвал тэр тохиолдолд хуулиараа дараагийн хүнийг 14 хоногийн дотор дахин дэвшүүлэх ийм зохицуулалт үйлчилж байгаа юм.

Тийм учраас нөгөө мандатын тоотой тэнцүү тооцоо хүнийг нэр дэвшүүлнэ ээ гэдэг нь хуулийнх нь шаардлага нь ийм байгаа юм. Ингээд 19 хоногийн хугацаатай бэлдээд, нэр дэвшигчийн сонсгол 01 сарын 08-ны өдөр явагдаад, сонсголоос тайлан маань, үүнээс хойш 5 хоног. Тэгээд 14 хоног гэдэг 2 хуулийн заалттайгаар нийлээд 19 болж байгаа.

Тэгээд сонсголын тайлан ороод ирэхээр, дахиад яг тухайн хүмүүс дээр эцсийн санал хураалт бол юун дээрээ Байнгын хороон дээр дахиж хураагдах ийм хуулийн дэгтэй байгаа.

Р.Сэддорж: Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Тэгвэл Тамгын газраас би нөгөө Ганхуяг гишүүний асуултыг л гүйцээгээд байгаа юм л даа. Одоо ингээд сонсголд хүн орж ирэхээр бид нар дэмжихгүй бол тэр хүн унаж болно биз дээ. Түүнийг албан ёсоор хариулаад өгөөч.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын Тамгын газраас хариулт.

Ү.Амарбат: Сонсголоор орж ирсэн хүнийг Улсын Их Хурлын тухайн холбогдох Байнгын хороо заавал дэмжих үүрэггүй. Хэрвээ тухайн хүнийг буцаавал

хуулиараа нэр дэвшүүлэх эрхтэй этгээд 14 хоногийн дотор дахин нэр дэвшүүлнэ ээ гэдэг хуулийн зохицуулалт үйлчилж байгаа.

Р.Сэддорж: Ганхуяг гишүүн энэ асуудалтай холбоотой юу? Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Яах вэ, бид нар бас зөвшилцөөд явах нь зөв байх л даа. Гэхдээ энэ дотор чинь насаараа Голомтод ажилласан нэг хүн явж байгаа байхгүй юу. Тэгээд үүнийг хяналтын зөвлөлд оруулж болохгүй. Арилжааны банканд ажиллаж байсан ийм хүн Монголбанкны хяналтын зөвлөлд орохоор чинь юу болох вэ? Насаараа ажилласан хүн байна шүү дээ. Хэн гэж хүн байна. Хосжаргал гэж хүн байна. Эрдэнэбаяр гээд дандаа л нөгөө цагдаа, прокуророор явж байсан хүн байхгүй юу. Ийм хүн болохгүй шүү дээ. Тэгээд би тийм учраас нэг 2, 3 анкет илүү байвал яасан юм бэ? Эсвэл энэ дээр бид нар анхнаас нь эсвэл хасчих, энэ 2 хүнээ. Энэ чинь ашиг сонирхлын зөрчил байхгүй юу. Арилжааны банкны ажилтан төв банк дээр очиж хяналт тавина гэж юу гэсэн үг юм бэ? Тэгээд энийгээ хасах хэрэгтэй байх, тэгвэл.

Р.Сэддорж: Одоо энэ нэр дэвшээд санал хураах гэж байгаа хүмүүс бол бүгдээрээ хуулийн шаардлагыг нь хангаж байгаа хүмүүс юм байна. Хангахгүй хүмүүс нь хасагдаад, бүгдээрээ өөрсдөө хангахгүй байгаа үндэслэлүүдээ хүлээн зөвшөөрчихсөн, ийм нэрсүүд орж ирж байгаа юм.

Одоо ингээд санал хураалт явах гэж байна шүү дээ. Энэ Жаргалан гишүүнд саяын жагсаалтаа өгчхөөч. Үгүй ээ, энэ нөгөө жагсаалт нь байгаа биз дээ.

Санал хураалт явуулъя.

Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшүүлж, Ууганбаатарыг Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшүүлж байна. Дэмжье гэсэн, Ууганбаатарыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

70 хувийн саналаар Ууганбаатар дэмжигдлээ. Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргад Ууганбаатарын нэрийг дэвшүүлэхээр шийдвэрлэлээ.

Одоо Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшихээр ирүүлсэн хүсэлтүүдээр санал хураалт явуулъя. Нийт 6 хүн нэр дэвшүүлэхээр байгаа. 14 хүн нэр дэвших хүсэлтээ ирүүлсэн байна. Эдгээрээс 6-г бид сонгож нэр дэвшүүлнэ.

Ингээд санал хураалт үргэлжлүүлэн явуулъя.

Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Ц.Бархасыг дэмжиж байгаа гишүүд саналаа өгье. Дэмжье гэсэн томьёоллоор. Ц.Бархас. санал хураалт.

Ингээд Ц.Бархас санал авсангүй, дэмжигдсэнгүй.

Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Г.Батхонгор дээр. Батхонгорыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

5 хувийн саналаар Батхонгор дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны ажлын албанаас өөр хүмүүс байхгүй биз дээ, энд.

Гишүүд санал хураалтад идэвхтэй оролцъё. Анхааралтай байгаарай.

Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Д.Ганбаярыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Жаргалан гишүүн. Алдаржавхлан гишүүн горимын санал.

Ж.Алдаржавхлан: Сая юу болоогүй учраас санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна.

Р.Сэддорж: Алдаржавхлан гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт. Хүчингүй болгохыг дэмжье гэсэн томъёоллоор.

35 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Цогтгэрэл гишүүний микрофоныг нээе.

О.Цогтгэрэл: Саяын санал хураалтад миний санал эсрэг гарчихсан. Би бас хоцорч орж ирээд эсрэг гарчихлаа. Бас энэ санал хураалтад оролцох бололцоог хангаж өгөөч.

Р.Сэддорж: Цогтгэрэл гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн энэ саналын томъёоллоор санал хураалт.

45 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал хураалт.

Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд С.Лхагвадоржийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

40 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Сая С.Лхагвадорж дэмжигдсэнгүй.

Дараагийн санал хураалт.

Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд Д.Моломжамцыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

20 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Ингээд Д.Наранхүү, И.Оюунжаргал, Пүрэв нар материалаа татсан байна.

Ингээд Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд Р.Пүрэвийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Пүрэв.

Та горимын санал гаргах уу? Ганхуяг гишүүн горимын санал гаргая.

Х.Ганхуяг: Дарга аа, энэ сүүлийн, манайхан идэвхтэй, байж байгаарай. Пүүжээ гишүүн та битгий хурал үймүүлээд байгаач. Сүүлийн 2 санал дээр миний энэ санал хураалт, тийм энэ тоног төхөөрөмж дээр асуудал үүссэн үү, эсвэл хуруу уншигдсангүй юу. Сүүлийн 2 саналд хоёулан дээр нь болсонгүй. Моломжамц гуай болон энэ сүүлийн сая Пүрэв гэдэг залуу дээр дахиад санал хураалт явуулж өгнө үү, дарга аа.

Хамаагүй шүү дээ. Үгүй ээ, тэгээд 74-тэйдээ Трамп өнөөдөр ажиллаад л явж байна шүү дээ. Сүүлийн 2 санал хураалтыг дахиад дарга аа, дахиад явуулаад өгөөч ээ л гэж хүсэх гэсэн юм. Болох уу? Тийм, хуруу ерөөсөө болохгүй байна.

Р.Сэддорж: Тийм, Моломжамц гуай материал өгөөгүй юм байна. Огт өгөөгүй юм байна. Тийм, материал өгөөгүй юм байна.

Сүүлийн, сүүлийн санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн. Хүчингүй болгоё гэсэн томъёоллоор. Санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт.

Батсүмбэрэл гишүүн горимын санал гаргая.

Н.Батсүмбэрэл: Сая яасангүй ээ, утсаар ярьж байгаад саналаа өгч амжсангүй. Санал хураалтыг дахиж явуулж өгнө үү.

Р.Сэддорж: Батсүмбэрэл гишүүний гаргасан горимын саналаар энэ саяын санал хураалтыг хүчингүй болгохыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд Р.Пүрэвийг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

55 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ. 55 хувиар санал дэмжигдлээ.

Сайнзориг гишүүн горимын санал гаргая.

П.Сайнзориг: Хүсэлтүүдээ халти яаж байгаа юм. Сая ингээд гишүүдтэйгээ ингэсэн чинь банк бустай хүн жишээ нь банкны, Монголбанкны Хяналтын зөвлөлд дэвшиж байгаа байхгүй юу. Болно шүү дээ. Банк бусыг чинь Санхүүгийн зохицуулах хороо хянаж байгаа байхгүй юу. Ийм юмнаас хүний нөөцийн хомсдолтой явж байж, хэдүүлээ ингээд учир зүйг нь ойлгохгүй, ийм мэдээллээр ингээд Байнгын хорооноос яагаад. Би жишээ нь сая хэн гэхэв. Энэ Лхагвадорж банк бустай учраас бид хэд унагаачихлаа гэж байгаа байхгүй юу. Болохгүй шүү дээ. Тэгээд юунд нь дэвшиж байгаа юм гэсэн чинь, Монголбанк. Ийм эрх ашгийн зөрчилдөөнд зөрөөд байгаа хүмүүсээ хэдүүлээ нээлттэй сонсголоо оруулаад сонсож үзмээр байгаа байхгүй юу. Тэгэхгүй ингээд өнөөдөр ингээд бид хэд аймаар буруу мэдээлэл, би сая уучлаарай. Хууль зүйн байнгын хороо зэрэг Цэцийн 2 дүгнэлтийг хүлээж авах уу гээд явчихаар, би сая хоцроод орж ирж байгаа. Та хэдийгээ хүндэтгэж байна. Уучлаарай, ажилд байна саад болоод байгаа.

Тэгэхдээ саяын энэ ярьж байгаа энэ мэдээллүүд зарчмын хувьд буруу яваад байна. Хэдүүлээ хаана, хэн нь эрх ашиг нь зөрчигдөөд байгаа, тэгээд сонсголоороо

оруулаад тэр 45 хүнийг ч гэсэн сонсголоор оруулахад буруудах юм бараг уг нь байхгүй байхгүй юу. Тэгэхдээ дэг нь ийм юм байна. Тэгэхдээ ер нь зүгээр та ядаж нэг чиглүүлээд, ийм хүн байна, ийм мэргэжлийн хүн байна шүү гэхгүй бол би зүгээр сая энд ирээд суухад Монголбанкны Хяналтын зөвлөл дэвшиж байгаа хүнийг тэгээд л унагаачихаар чинь Монголд тийм их олон хүний нөөц байдаг юм уу гээд би сайн мэдэхгүй байна.

Тэгэхээр энэ дээр нь би жишээ нь саяын хүн дээр ч гэсэн зүгээр л горимын санал гаргая. Дахин санал хураалгая. Ядаж хэдүүлээ ийм зарчмыг нь тогтоож өгөхгүй бол энэ чинь сүүлдээ дараа дараагийн хүмүүс дээр чөдөр болно шүү. Олон ч хүмүүсийг улс төрийн дэмжлэгийг нь үзүүлэхгүй. Чи хувьдаа худалдааны компанитай юм байна гэнгүүтээ дэд сайд дээр ч унагааж байсан үе байдаг. Тэгэхдээ тэр ашиг сонирхлоо ил тод мэдүүлээд, шийдвэр гаргахдаа үүнийгээ гаргахгүй байх нь чухал байдаг болохоос биш хэдүүлээ ийм зарчим тогтоож болохгүй байх. Би тэгэхээр сая аль санал дээр нь унасан юм бол би түүн дээр нь горим гаргамаар байна. Ингэж, энэ өөрөө ашиг сонирхлын зөрчлийг хэдүүлээ хавтгайруулж ингэж үзэж болохгүй. Би цаана нь зарчим ярих гээд байгаа юм шүү.

Р.Сэддорж: Т.Тэлмэн 1978 онд төрсөн. Бизнесийн удирдлагын мэргэжилтэй, Амар даатгал компанид ажиллаж байсан туршлагатай. Ингээд Т.Тэлмэнийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

35 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3 цаг хүртэл. Цуглана, цуглана. Бүгдээрээ 4 цагаас зарим нь Байнгын хорооны хуралтай. Түүнээс өмнө санал хураалтаа энэ ирцээрээ явна гэсэн үг. Бүгдээрээ бас намын бүлгүүд дотроо асуудлуудаа ярина.

3 цаг хүртэл хойшлууллаа.

Завсарлууллаа.

ЗАВСАРЛАГА

Р.Сэддорж: Байнгын хорооны хуралдааныг үргэлжлүүлэн явуулъя.

Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнд тус тус нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшихээр ирүүлсэн хүсэлтүүдээс санал хураалт явуулна. Нийт 6 хүн нэр дэвшүүлэхээр байгаа. 14 хүн нэр дэвших хүсэлтээ ирүүлсэн. Иймээс гишүүд санал хураалтад анхааралтай оролцож, дэмжиж буй хүсэлт ирүүлэгчид саналаа өгнө.

Ингээд 1 дүгээрт, Сугарын Лхагвадорж 1985 онд төрсөн, эдийн засагч мэргэжилтэй. 2019 оноос одоог хүртэл Дарь Финанс ББСБ-ын гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа. Ингээд Сугарын Лхагвадоржийг дэмжиж байгаа Байнгын хорооны гишүүд дэмжье гэсэн томьёоллоор саналаа. Санал хураалт.

Байнгын хорооны гишүүдийн 70,6 хувийн саналаар Сугарын Лхагвадоржийг дэмжлээ.

Дараагийн хүн. Тунсагийн Тэлмэн 1978 онд төрсөн, бизнесийн удирдлага мэргэжилтэй. Амар даатгал компанид захирлаар ажилтай. Тунсагийн Тэлмэнийг дэмжиж байгаа Байнгын хорооны гишүүд дэмжье, Тунсагийн Тэлмэнийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

70,6 хувийн саналаар Тунсагийн Тэлмэн дэмжигдлээ.

Гэрэлтийн Тэлмэн дараагийн хүн. 1985 онд төрсөн, олон улсын эдийн засгийн харилцаа мэргэжилтэй. Монгол шуудан компанийн гүйцэтгэх захирлын ажилтай. Гэрэлтийн Тэлмэнийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

70,6 хувийн саналаар Гэрэлтийн Тэлмэн дэмжлээ.

Дараагийн хүн. Гомбын Эрдэнэбаяр 1958 онд төрсөн, хуульч мэргэжилтэй. Монголбанкны Хууль, эрх зүйн газарт ахлах мэргэжилтнээр 2016-аас 21 онд ажиллаж байсан. Гомбын Эрдэнэбаярыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

76,5 хувийн саналаар Гомбын Эрдэнэбаяр дэмжигдлээ.

Дараагийн хүн. Данзанбалжирын Энхжаргал 1964 онд төрсөн, эдийн засагч мэргэжилтэй. Европ дахь Монголын эмэгтэйчүүдийн хөгжлийн холбоо, Эрдэс баялгийн эмэгтэйчүүдийн холбооны үүсгэн байгуулагч, “Санхүү банкны эмэгтэйчүүд”, “Даян дэлхийн Монгол эмэгтэйчүүд хамтдаа” зэрэг төрийн бус байгууллагуудын ерөнхийлөгч, тэргүүн зэргийг хийж байгаа ийм эмэгтэй байна. Данзанбалжирын Энхжаргалыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

70,6 хувийн саналаар Данзанбалжирын Энхжаргалыг дэмжлээ.

Дараагийн хүн Ундраагийн Хосжаргал 1983 онд төрсөн, эдийн засагч мэргэжилтэй. BPM Mongolia компанийн гүйцэтгэх захирлын ажилтай. Ундраагийн Хосжаргалыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

64,7 хувийн саналаар Ундраагийн Хосжаргал дэмжигдлээ.

Протоколд Мандхай гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

Намсрайн Батнасан Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нийт 4 нэр дэвшигч байна.

Намсрайн Батнасан 1970 онд төрсөн, эдийн засагч мэргэжилтэй. 2023 оноос МУИС-ийн Бизнесийн сургуулийн захирал. Монголбанкны Мөнгөний бодлогын хороонд орон тооны бус гишүүнд нэр дэвшигч Намсрайн Батнасанг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

64,7 хувийн саналаар Намсрайн Батнасанг дэмжлээ.

Жаргалан гишүүнийг дэмжсэнээр протоколд тусгая.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд Раднаасэдийн Даваадоржийг. 1968 онд төрсөн, эдийн засагч мэргэжилтэй. 2024 оны 09 сараас Улсын Их Хурлын дэд даргын зөвлөхийн ажилтай. Раднаасэдийн Даваадоржийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

76,5 хувийн саналаар Раднаасэдийн Даваадоржийг дэмжлээ.

Батбаатарын Мөнхзаяа 1984 онд төрсөн, эдийн засагч мэргэжилтэй. 2021 оноос Санхүү, эдийн засгийн их сургуулийн Бакалаврын сургалт, судалгааны албаны проректор ажилтай ийм хүн байна. Батбаатарын Мөнхзаяаг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

70,6 хувийн саналаар Батбаатарын Мөнхзаяа дэмжигдлээ.

Бямбажавын Энх-Амгалан 1977 онд төрсөн, эдийн засагч мэргэжилтэй. МУИС-ийн Бизнесийн сургуулийн дэд профессор. Бямбажавын Энх-Амгаланг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

70,6 хувийн саналаар Бямбажавын Энх-Амгаланг дэмжлээ.

Ундраа гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшихээр ирүүлсэн хүсэлтүүд дээр санал хураалт явууля.

Нийт 1 хүний нэр дэвшүүлнэ. 8 хүн нэр дэвших хүсэлтээ ирүүлсэн. Иймээс гишүүд санал хураалтдаа анхааралтай оролцохыг хүсье.

Булганы Саруул 1980 онд төрсөн, эдийн засагч мэргэжилтэй. 2024 оны 12 дугаар сараас Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч. Ингээд Булганы Саруулыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

70,6 хувийн саналаар Булганы Саруулыг дэмжлээ.

Ингээд Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцье.

Даргын хамт нийт 3 хүнийг нэр дэвшүүлэхээр байгаа. 7 хүн хүсэлтээ ирүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн даргад Мягмарсүрэнгийн Буяндэлгэрийг дэвшүүлж байна. 1980 онд төрсөн, эрх зүйч мэргэжилтэй. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Хот, хөдөөгийн сэргэлт, зохион байгуулалт, хот төлөвлөлтийн үндэсний хорооны аж ахуйн дарга, ажлын албаны дарга. Мягмарсүрэнгийн Буяндэлгэрийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

58,8 хувийн саналаар Мягмарсүрэнгийн Буяндэлгэрийг дэмжлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлд, гишүүнд Оюунтөгсийн Оч. 1988 онд төрсөн, эдийн засагч мэргэжилтэй. 2024 оноос Ньюком компанид

Хөрөнгө оруулалт эрхэлсэн захирлын ажилтай. Оюунтөгсийн Очийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

64,7 хувийн саналаар Оюунтөгсийн Очийг дэмжлээ.

Болдбаатарын Энхбаяр 1982 онд төрсөн, эдийн засагч, бизнесийн удирдлагын эрх зүйч мэргэжилтэй. Верчу консалтинг компанийн захирлын ажилтай. Болдбаатарын Энхбаярыг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшихийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

70,6 хувийн саналаар Болдбаатарын Энхбаярыг дэмжлээ.

Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнд нэр дэвшихээр ирүүлсэн хүсэлтүүдээр санал хураалт явуулъя.

1 хүний нэр дэвшүүлнэ. 3 хүн нэр дэвших хүсэлтээ ирүүлсэн. 1 хүнийг ажлын албанаас шууд дэвшүүлж байна.

1 дүгээрт, Төмөрбаатарын Гарамжүгдэр 1988 онд төрсөн. Эдийн засагч мэргэжилтэй. 2022 оноос 24 онд ABAG dvreening компанид ажилладаг. Төмөрбаатарын Гарамжүгдэрийг Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнд нэр дэвшихийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

70,6 хувийн саналаар Төмөрбаатарын Гарамжүгдэрийг дэмжсэнд тооцлоо.

Дамдиндоржийн Мягмарцэрэн 1975 онд төрсөн, хуульч мэргэжилтэй. Улсын Их Хурлын Тамгын газар Эдийн засгийн байнгын хорооны ахлах зөвлөх ажилтай. Дамдиндоржийн Мягмарцэрэнг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт санал хураалт.

Санал хураалтыг цуцалъя. Гацчихлаа. Санал хураалтыг дахин явуулъя.

58,8 хувийн саналаар Дамдиндоржийн Мягмарсүрэн дэмжигдлээ.

Статистикийн хорооны зөвлөлд Их Хурлаас 3 хүн оруулах ийм мандаттай. Тэгээд 1 нь бол ШУА-аас ордог.

Авирмэдийн Даваасүрэн Эдийн засгийн шинжлэх ухааны доктор, профессор. Энэ хүнийг сонголд оруулахыг санал хураалтгүйгээр шууд сонголд оруулахаар шийдэж байна. Энэ ШУА-аас 1 хүн зүгээр танилцуулж байгаа, Байнгын хороондоо. Тийм квот, квотоор.

Гишүүд санал хураалтаараа шийдээд явсан.

Санал хураалт дууссан.

16.07 цаг

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, холбогдох бусад хуульд заасны дагуу нэр дэвшүүлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтны ирүүлсэн нэр

дэвшигчийг шууд нэр дэвшигчийн сонголд оруулж, сонголоор хэлэлцэх учраас өнөөдрийн нэр дэвшүүлэх хэлэлцүүлэгт оруулаагүй болно.

Улсын Их Хурлын дарга Санхүүгийн зохицуулах хорооны даргад, Сангийн сайд Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус 1 гишүүнд, Монголбанкны Ерөнхийлөгч Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус 1 гишүүнд, ШУА-ийн Ерөнхийлөгч Үндэсний статистикийн хорооны 1 гишүүнд тус тус нэр дэвшүүлэх саналаа Байнгын хороо дээр ирүүлсэн. Эдгээр нэр дэвшигчдийг 2025 оны 01 дүгээр сарын 14-нд болох Байнгын хорооны томилгооны сонголоор хэлэлцэж, томилуулахаар чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлнэ.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Хуралдаа идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ